

Хавсралт 2

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ
(Өөрчлөлт оруулах санал)

Нэгдүгээр бүлэг
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын үндэсний татварын тогтолцоо, албан татвар, хураамж, төлбөрийн нийтлэг зарчим, татвар төлөгчийн эрх, үүрэг хариуцлага, Үндэсний татварын албаны, татварын албадад ажиллаж буй төрийн албан хаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл Монгол Улсын татварын хууль тогтоомж

- 2.1. Монгол Улсын татварын хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.1.1. Үндэсний татварын ерөнхий газар нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлал, зөвлөмж гаргана. Энэ нь хуулийг өөрчлөх үндэслэл болохгүй.
- 2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
- 2.3. Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл Хуулийн нэр томъёо (Шинэ зүйл)

- 3.1. Энэ хуульд дурьдагдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:
- 3.1.1. **Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан гэдэгт** уг орлого, орлогоос бусад зүйлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулах, нягтлан бодох бүртгэл болон татварын тайланд санаатайгаар буруу бичилт хийх, хууль бус хэлцэл хийж хууран мэхлэх, холбогдох баримт бичгийг гаргаж өгөхгүй байх, хуурамчаар өглөг үүсгэх, түүнчлэн баримт бичгийг татвар төлөхгүйн тулд хуурамчаар үйлдэх, аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэр, хаяг, тамга тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөл болон эд хөрөнгө, иргэний бичиг баримтаа бусдад ашиглуулах замаар татвараас зайлсхийх боломж олгосон үйлдлийг;

- 3.1.2. **Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг санаатайгаар бууруулсан** гэж татвар ногдох зүйлийн тоо, хэмжээ нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд багасган тусгах, орлогоо багасгаж харуулахын тулд хуурамч баримт бичиг үйлдэх, зохиомлоор зардлаа өсгөх буюу орлогоо багасгахыг;
- 3.1.3. **Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан** гэж татвар ногдох орлого, татвар ногдох зүйлийн тоо хэмжээг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны үйлдэл алдах, түүнчилэн нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтөлж тайлан тэнцлээ зөв гаргасан боловч татвар ногдох орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүнг буруу тодорхойлсон үйлдлийг;
- 3.1.4. **Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсноор татвар төлөх үүрэг дуусгавар болох** гэж Улсын Их Хурал уг төрлийн татварын хуулийг хүчингүй болгож татварын тооцоог хийж өөр төрлийн татварт шилжүүлэх шийдвэр гарсан хугацаа дуусснаас хойшхи хугацаанаас тооцохыг;
- 3.1.5. **Татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн** гэж тухайн татвар төлөгч:
- ногдох татвараа хуульд заасан хугацаанд төлөөгүй;
 - хаягаа буруу тодорхойлсон;
 - хаягаа өөрчилсөн тухайгаа татварын албанд мэдэгдэж улсын бүртгэлийн гэрчилгээндээ тэмдэглэл хийлгээгүй;
 - нягтлан бодох бүртгэлийн болон тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ орлого, татвар тодорхойлох хуудсыг гаргаж өгөөгүй;
 - татварын алба болон татварын байцаагчаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй;
 - шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаа нь мэдэгдэхгүй байх зэргийг.
- 3.1.6. **Хүчингүй гэрээ, хэлцэл** гэж утга агуулгаараа хууль зөрчсөн, мэдрэлийн өвчтэй хүнтэй буюу хуулиас гадуур хийгдсэн, бага насны хүүхэд, сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио учир эрх олох, үүрэг бий болгох чадваргүй этгээдтэй хийсэн хэлцэл, айлган сүрдүүлэх буюу аргагүй гачигдлыг далимдуулан хийсэн хэлцлүүдийг, хуурамч гэрээ хэлцэл нь хууль ёсны үр дүн үзүүлсэн хэлцлийг;
- 3.1.7. **Хууль бус үйлдлээр олсон орлого** гэж тухайн ажил, үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг зөрчиж олсон орлогыг;
- 3.1.8. **Саад учруулсан** гэж татварын албаны ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэлийн болон тайлан тэнцэл, татварын тайлан мэдээг гаргаж өгөхгүй байх, байр агуулахад нэвтрэн орох боломж олгохгүй байх, тооллого тооцоог будлиантуулах түүнчлэн үзлэг шалгалт, ажлын зураг авалтыг хийлгэхгүй байх зэрэг санаатай үйлдэл эс үйлдэхүйг;

- 3.1.9. **Эсэргүүцэл** гэж татварын албаны байцаагч болон ажилтныг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цохих, өшиглөх, түлхэх, аливаа зүйлээр цацах, сэтгэл зүйн эсэргүүцэл үзүүлэх, биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэх эсхүл биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэхээр заналхийлэх, хэл амаар доромжлох үйлдлийг;
- 3.1.10. **Шилжүүлсэн орлого** гэж гэрээ хэлцлийн үндсэн дээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг бэлэн буюу бэлэн бусаар тухайн аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлсэн, ажил, үүрэг гүйцэтгэсний төлөө авах цалин, хөдөлмөрийн хөлс, төлбөрийг ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар нь дамжуулан олгохоор шилжүүлсэн орлогыг;
- 3.1.11. **Татвар төлөгч байгууллага** гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татварын алба болон бусад бүртгэх байгууллагад бүртгүүлсэн энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар татвар төлөгч байгууллага гэж тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага, санг;
- 3.1.12. **Ашгийн төлөө байгууллага, сан** гэж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр, төрийн бус байгууллага, сангаас өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааг явуулах нөхцлийг хангахад зориулан үйлдвэрлэл үйлчилгээ явуулж олсон орлого нь зардлын 50 хувиас хэтэрсэн байвал;
- 3.1.13. **Үл маргах журмаар гаргуулна** гэж татвар төлөгчөөс хуульд буюу татварын албаны заасан хугацаанд төлөөгүй татвар, алданги торгуулийн төлбөрийг түүний банкин дахь мөнгөн хөрөнгөнөөс татварын байгууллагын шийдвэрээр татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр гаргуулан авахыг. Хэрэв татвар төлөгчийн банкин дахь мөнгөн хөрөнгө нь татвар, алданги, торгуулийг төлөхөд хүрэлцэхгүй байвал уг данснаас гаргах зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож дансанд орох орлогоос гаргуулан авахыг;
- 3.1.14. **Бусад олгосон хөдөлмөрийн хөлс, цалин** гэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс бэлэн буюу бэлэн бусаар бусад этгээдэд олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогыг
- 3.1.15. **Дундын суутгал** гэж
- аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс бэлэн мөнгөөр хийгдсэн бол дундын суутгал хийгдсэн байхыг,
 - хөдөлмөрийн хөлс, цалин тэдгээртэй адилтгахаар энэ хуульд заасан цалин болон хөдөлмөрийн хөлсийг хувийн ба хадгаламж, зуучлагчийн дансанд шилжүүлэгдсэн бол дундын суутгал хийгдсэн байхыг;
 - үндсэн байгууллагаар нь дамжуулан олгохоор шилжүүлснээс бусад тохиолдлыг;
- 3.1.16. **Татварын өр** гэж тухайн татварын хуулиар тогтоогдсон хугацаанд нь төлөөгүй татварын дүн, тэдгээрт ногдсон алданги, торгууль, татварын хяналт шалгалтаар илэрч төлөгдөхөөр тогтоогдсон нөхөн татвар, алданги, торгуулийг;
- 3.1.17. **Татвар ногдох орлого** гэж татвар төлөгчийн үндсэн болон бусад үйл ажиллагаанаас олсон нийт орлогыг;

- 3.1.18. **Татвар ногдуулах орлого** гэж татвар төлөгчийн татвар ногдох орлогоос тухайн төрлийн татварын хуулиар тодорхойлогдсон зардлыг хассан дүнг;

4 дүгээр зүйл *Үндэсний татварын тогтолцоо (Хуучин 3-р зүйл)*

- 4.1. Үндэсний татварын тогтолцоо нь албан татвар, хураамж, төлбөр (цаашид "татвар" гэх)-өөс бүрдэнэ.
- 4.1.1. Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ. Албан татвар шууд болон шууд бус татвараас бүрдэнэ;
- 4.1.2. Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хураамж гэнэ;
- 4.1.3. Төрийн өмч (иргэдэд өмчлүүснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг) ашигласаны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төлбөр гэнэ.

5 дугаар зүйл *Татвар бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох, түүний хувь хэмжээ (Хуучин 4-р зүйл)*

- 5.1. Татварыг Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно.
- 5.1.1. Татварын хувь, хэмжээ, түүнийг өсгөх, бууруулах хэмжээг Улсын Их Хурал тогтооно. Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээнд багтаан түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.

6 дугаар зүйл. Татвар төлөгч (Хуучин 5-р зүйл)

- 6.1. Хуулийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, тодорхой эрх бүхий, эсхүл эд хөрөнгө эзэмшин ашиглаж байгаа дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөгч байна;
- 6.1.1. Монгол Улсын иргэн;
- 6.1.2. Тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүн, Монгол Улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд;
- 6.1.3. Тус улсын нутаг дэвсгэрт байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллага, сан;
- 6.1.4. Тус улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар

- 6.1.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эх үүсвэрээс орлого олж байгаа оршин суугч бус гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар;
- 6.1.6. Байнга болон түр оршин суугчийг тухайн төрлийн татварын хуулиар тодорхойлж болно.
Энэ зүйлийн 6.1.1, 6.1.2-д заасан татвар төлөгчийг цаашид "иргэн" гэнэ.

7 дугаар зүйл Татвар төлөгчийг бүртгэх (Хуучин 6-р зүйл)

- 7.1. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага нь татварын албанд бүртгүүлнэ.
- 7.2. Татвар төлөгчийг бүртгэх зарчмыг татварын хуулиар тогтоох ба бүртгэх журмыг Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар батална.

8 дугаар зүйл Татвар ногдох зүйл (Хуучин 7-р зүйл)

- 8.1. Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц хамаарна.

9 дугаар зүйл Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хэлбэр (Хуучин 8-р зүйл)

- 9.1. Хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчид дараахь хэлбэрээр татварын хөнгөлөлт үзүүлэх буюу түүнийг татвараас чөлөөлнө.
- 9.1.1. Ногдуулсан татварыг хорогдуулах;
- 9.1.2. Татварын хувь, хэмжээг бууруулах;
- 9.1.3. Татвар төлөгчийг дэмжих, үйл ажиллагааг нь урамшуулах, тухайн бүс нутгийг хөгжүүлэх, ажилгүйдлийг багасгах зорилгоор тодорхой зориулалт бүхий татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
- 9.1.4. Тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээг татвараас чөлөөлөх;
- 9.1.5. Татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;
- 9.1.6. Татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;
- 9.1.7. Хууль тогтоомжид заасан бусад хөнгөлөлт

10 дугаар зүйл Татвар төлөх журам (Хуучин 9-р зүйл)

- 10.1. Татварыг татварын тайлан буюу орлого, татвар тодорхойлох хуудсаар, Төсвийн тухай хуулийн дагуу татварын албанаас баталсан сар, улирлын хуваарийн дагуу урьдчилан эсхүл суутгал хийх замаар ногдуулж, төлбөрийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр гүйцэтгэнэ. Энд зааснаас өөрөөр татвар ногдуулж төлөх журмыг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.

- 10.2. Татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно. Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна. Хэрэв энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцвал түүний өмнөх ажлын өдөр татварыг төлж тайлагнана.
- 10.3. Тогтоосон хугацаанд төлөөгүй татвар болон нөхөн ногдуулсан татвар, алданги, торгуулийг татвар төлөгчөөс үл маргалдах журмаар гаргуулна.
Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх тооцоо хийсэн этгээдэд татварын албанаас төлбөр тооцооны ажил, үйлчилгээний хөлс, шимтгэл олгохгүй.
- 10.4. Аж ахуйн нэгж, байгууллага шууд бус татварыг өөрийн үйл ажиллагааны үр дүн гарахыг хүлээлгүй төсөвт төлнө.
- 10.5. Татвар ногдох орлогыг нэхэмжилсэн, падаан бичигдсэн, төлбөр хийгдсэн өдрийн аль түрүүчийнхээр нь тооцно.
- 10.6. Аж ахуйн нэгж, байгууллагын татвар ногдуулах, төлөх тооцоог татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гүйцэтгэнэ.

11 дугаар зүйл Татвар төлөгчийн үүрэг (Хуучин 10-р зүйл)

- 11.1. Татвар төлөгч дараахь үүрэг хүлээнэ.
- 11.1.1 Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газраас хууль тогтоомжинд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дагаж мөрдөнө;
- 11.1.2. Татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх, оны эхэнд татварын албатай тохиролцсон хуваарийн дагуу албан татварын урьдчилгааг төлөх;
- 11.1.3. Татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх;
- 11.1.4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах;
- 11.1.5. Татварын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар татварын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх;
- 11.1.6. Татварын албаны шалгалтын актыг зөвшөөрч байгаа бол гарын үсэг зурах, актыг зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсны тайлбараа ажлын 10 хоногийн дотор Татварын албанд бичгээр гаргаж өгнө;
- 11.1.7. Тухайн төрлийн татварын хуулиар дундын суутгал хийгдэхээр заагдсан бусдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого ба шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган авч, хуульд заасан хугацаанд төсөвт төлөх;
- 11.1.8. Тухайн төрлийн татварын хуулиар тусгайлсан хувиар татвар ногдуулахаар заагдсан орлогод татвар ногдуулж хуульд заасан хугацаанд төсөвт төлөх;
- 11.1.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь дундын суутгал хийж шилжүүлсэн орлогод ногдох татварын ногдуулалт, төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр, хаяг, регистрээр улирал тутам гаргаж өөрийн харъяалагдах татварын албанд өгөх;

- 11.1.10. Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь энэ тухай баримтыг татварын албанд гаргаж өгөх;
- 11.1.11. Өөрийн нэр хаяг, тамга тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, харилцах болон хувийн дансыг бусдад ашиглуулан татвараас зайлсхийх боломж олгохгүй байх ;
- 11.1.12 Өөрийн тамга, тэмдэг, нэр хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээслэх, худалдан борлуулахгүй байх;
- 11.1.13. Банкин дахь дансаа нээсэн, хаасан хугацааг харьцдаг татварын албанд ажлын 3 хоногт багтаан мэдэгдэх;
- 11.1.14. Батлагдсан техникийн шаардлага хангасан кассын машин хэрэглэх;
- 11.1.15. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.
- 11.2. Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргах үед татвар төлөгч нь дараах үүрэг хүлээнэ:
 - 11.2.1. Маргаан таслах зөвлөлд хянан хэлэлцэх асуудлын талаар нэмэгдэл нотлох баримтыг гаргаж өгөх;
 - 11.2.2. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд болон уг асуудлыг шалган магадлаж байгаа ажилтанд шаардлагатай тайлбарыг өгөх;
 - 11.2.3. Зөвлөлийн шийдвэрийг шүүхэд давж заалдсан тохиолдолд шүүх хуралд тэмдэгтийн хураамж төлж оролцох

12 дугаар зүйл *Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих (Хуучин 11-р зүйл)*

- 12.1. Татвар төлөх үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно.
 - 12.1.1. Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон үед. Гэхдээ тухайн татварын хууль хүчингүй болохоос өмнө тухайн хуулийн дагуу татвар төлөх үүрэг буй болж байсан тохиолдолд тус татвар төлөх үүрэг дуусгавар болохгүй.
 - 12.1.2. Тухайн төрлийн татварыг төлж дууссан;
 - 12.1.3. Татвар төлөгч тухайн төрлийн татвараас бүрэн чөлөөлөгдсөн;
 - 12.1.4. Татвар төлөгч иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон;
 - 12.1.5. Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан.
- 12.2. Нас барсан, нас барсанд тооцогдсон иргэний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь шилжинэ.
- 12.3. Өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын татварын өрийг төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өөрчлөн байгуулагдсаны дүнд бий болсон аж ахуйн нэгж, байгууллагад шилжинэ. Аж ахуйн нэгж, байгууллага тусгаарласан, салсан тохиолдолд татвар ногдох зүйлтэй хувь тэнцүүлэн татвар төлөх үүрэг тэдгээрт шилжинэ.
- 12.4. Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан бол татан буулгах комисс, дампуурсан бол нэхэмжлэгчдийн зөвлөл төлөөгүй буюу дутуу төлсөн татварыг уг аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж төлнө.

13 дугаар зүйл Татвар төлөгчийн эрх (Хуучин 12-р зүйл)

- 13.1. Татвар төлөгч дараахь эрх эдэлнэ:
- 13.1.1. Татварын хууль тогтоомжид заасан нөхцөлд хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх, хэд хэдэн нөхцөлөөр хөнгөлөлт эдлэх тохиолдолд аль нэгийг нь сонгон авах;
- 13.1.2. Татварын албаны шалгалтын акттай танилцах;
- 13.1.3. Татвар ногдуулалт, төлөлт, шалгалтын дүнгийн талаар тайлбар өгөх буюу авах;
- 13.1.4. Татварын албаны буруугаар учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;
- 13.1.5. Илүү төлсөн татварыг эргүүлэн авах буюу суутган тооцуулах;
- 13.1.6. Татварын алба, түүний байцаагчийн хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлоо эрх бүхий байгууллага болон шүүхэд хууль тогтоомжийн дагуу гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.
- 13.2. Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргах үед татвар төлөгч дараах эрх эдэлнэ:
- 13.2.1. Гомдол гаргаж буй татвар төлөгч нь татварын алба, татварын улсын байцаагчийн гаргасан шийдвэртэй танилцаж үндэсгүй үзвэл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор гомдлоо харъяалах татварын маргаан таслах зөвлөлд гаргана;
- 13.2.2. Маргаан таслах зөвлөлийн хуралд биеэр оролцож тайлбар, үндэслэл, санал хүсэлтээ гаргах, өөрийн төлөөлөгч, итгэмжлэгдсэн нягтлан бодогч, өмгөөлөгчдийг хуралд оролцуулах;
- 13.2.3. Маргаан таслах зөвлөлийн хурал болохоос өмнө маргаж байгаа зүйлийн талаар бичгээр тайлбар, тодорхойлолт гаргаж өгөх;
- 13.2.4. Маргаан таслах зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэлтэй танилцах;
- 13.2.5. Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо дээд шатны татварын маргаан таслах зөвлөл болон шүүхэд шат дараалан гаргах.

14 дугаар зүйл Татвар төлөгчид алданги ногдуулах

- 14.1. Татвар ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан нь баримтаар нотлогдсон бол ногдох татварыг нөхөн төлүүлж, саатуулсан хоног тутам нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувиар алданги ногдуулах. Алдангид хязгаар тогтоохгүй.
- 14.2. Татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнгээс бодож хоног тутамд 0,5 хувиар тооцож алданги ногдуулах. Үүнд Иргэний хуулийн 180-р зүйлийн 6-р хэсгийн заалт хамаарахгүй.
- 14.3. Хууль тогтоомжоор хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй явуулж орлого олсон бол нөхөн ногдуулсан татварын дүнгээс бодож хоног тутамд 2 хувиар тооцож алданги ногдуулах.
- 14.4. Аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэр, хаяг, тамга тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний бичиг баримтаа бусдад ашиглуулах

орлого олсон буюу орлого олох боломжийг бусдад олгосон бол нөхөн ногдуулсан татварын дүнгээс бодож хоног тутамд 2 хувиар тооцож алданги ногдуулах.

15 дугаар зүйл Татвар төлөгчид хүлээлгэх хариуцлага (Хуучин 13-р зүйл)

- 15.1. Татварын хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татвар төлөгчид дараах хариуцлага хүлээлгэнэ:
- 15.1.1. Татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлоготой тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;
- 15.1.2. Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйл, түүний тоо хэмжээг нуусан буюу санаатайгаар бууруулсан нь баримтаар болон тооцоогоор нотлогдсон бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;
- 15.1.3. Аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэр, хаяг, тамга тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний бичиг баримтаа бусдад ашиглуулаж орлого олсон буюу орлого олох боломжийг бусдад олгосон нь баримтаар болон тооцоогоор нотлогдсон бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;
- 15.1.4. Хуулиар хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй явуулж олсон орлого болон ашигласан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, түүхий эд материалыг хураах
- 15.1.5. Хууль тогтоомжоор хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй явуулж олсон орлогыг бүрмөсөн хураах;
- 15.1.6. Хуурамч буюу хүчингүй гэрээ хэлцэл, хууль бус үйлдлээр олсон орлогыг бүрмөсөн хураах
- 15.1.7. Бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх.
- 15.1.8. Тогтоогдсон торгуулийг татвар төлүүлэхээр авсан өөр бусад арга хэмжээг хэрэглэснээс хамааралгүйгээр зэрэгцүүлэн төлнө.

16 дугаар зүйл Татвар, алданги, торгууль ногдуулах, төлөх хөөн хэлэлцэх хугацаа

- 16.1. Татвар, алданги, торгууль ногдуулах, төлөх хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна.
- 16.2. Хөөн хэлэлцэх хугацаа нь татварын зөрчлийг илрүүлэх хүртэл 5 жил, зөрчлийг илрүүлж акт дүгнэлт бичсэнээс хойш өр төлбөрийг барагдуулж дуусах хүртэлх 5 жилийн хугацааг хамаарна.
- 16.3. Татварын албанаас өр төлбөрийн мэдэгдэх хуудас өгсөн өдрөөр хөөн хэлэлцэх хугацаа тасалдаж, цааш шинээр тоологдоно.

17 дугаар зүйл Банк, санхүүгийн байгууллагын үүрэг, хариуцлага (Хуучин 14-р зүйл)

- 17.1. Банк, санхүүгийн байгууллага татварын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үзүүлэлтийг татварын албанд гаргаж өгнө.
- 17.2. Банкны байгууллага харилцагч аж ахуйн нэгж, байгууллагын татварын төлбөрийг 12 цагийн дотор гүйцэтгэх бөгөөд тухайн төлбөр хүлээн авсан банкны байгууллага тэр өдөрт нь багтаан төсвийн харилцах дансанд оруулах үүрэгтэй. Хэрэв уг үүргийг биелүүлээгүй бол татварын алба гүйцэтгээгүй татварын төлбөрийн дүнгээс бодож хоног тутам 0,5 хувийн алданги ногдуулна.
- 17.3. Татварын төлбөрийг үл маргах журмаар төлүүлэх тохиолдолд банк Татварын албаны мэдэгдлийг үндэслэн төлбөр хариуцагчийн харилцах данснаас уг төлбөрийг татварын албаны төсвийн орлогын дансанд оруулах үүргийг хүлээнэ.
- 17.4. Үндэсний татварын албаар дамжин улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж байгаа татвар, татварын нөхөн төлбөр, алданги, торгуулийн данс нь татварын албанд хөтлөгдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН АНГИЛАЛ

18 дугаар зүйл

Монгол Улсын татварын бүрэлдэхүүн (Хуучин 15-р зүйл)

- 18.1. Монгол Улсын татвар нь улсын болон орон нутгийн татвараас бүрдэнэ:
 - 18.1.1. Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газраас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх татварыг улсын татвар гэнэ.
 - 18.1.2. Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээнд багтаан түүний эрх олгосноор аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварыг орон нутгийн татвар гэнэ.
 - 18.1.3. Энэ хуулийн 18.1.1-д заасан татварын орлогоос орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх татварын нэр төрлийг Төсвийн тухай хуулиар зохицуулна.

19 дугаар зүйл

Улсын татвар (Хуучин 16-р зүйл)

- 19.1. Улсын татварт дараах татвар хамаарна:
 - 19.1.1. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар;
 - 19.1.2. Хүн амын орлогын албан татвар;
 - 19.1.3. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;
 - 19.1.4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
 - 19.1.5. Гаалийн албан татвар;
 - 19.1.6. Нэмэгдсэн өртгийн албан татвар;

- 19.1.7. Онцгой албан татвар;
- 19.1.8. Ашигт малтмалын нөөц ашиглах зөвшөөрлийн хураамж
- 19.1.9. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
- 19.1.10. Газрын төлбөр;
- 19.1.11. Автобензин, дизелийн түлшний албан татвар;
- 19.1.12. Автотээврийн болон өөрөө явагч хэрэслийн албан татвар;
- 19.1.13. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;
- 19.1.14. Тэмдэгтийн хураамж;
- 19.1.15. Гадаадад зорчиж буй иргэдийн албан татвар;
- 19.1.16. Утааны татвар

20 дугаар зүйл

Орон нутгийн татвар (Хуучин 17-р зүйл)

- 20.1. Орон нутгийн татварт дараахь татвар хамаарна:
 - 20.1.1. Бууны албан татвар;
 - 20.1.2. Нийслэл хотын албан татвар;
 - 20.1.3. Нохойны албан татвар;
 - 20.1.4. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;
 - 20.1.5. Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;
 - 20.1.6. Байгалийн ургамал ашигласны төлбөр;
 - 20.1.7. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;
 - 20.1.8. Ус, рашаан ашигласны төлбөр.

21 дүгээр зүйл

Татварын хувь, хэмжээг тогтоох (Хуучин 18-р зүйл)

- 21.1. Улсын Их Хурал энэ хуулийн 19.1.1-19.1.8, 19.1.10-19.1.11, 19.1.13-19.1.15, 20.1.1-20.1.3-д заасан татварын хувь хэмжээг тогтооно.
 - 21.1.1. Засгийн газар энэ хуулийн 19.1.10, 19.1.13, 20.1.4-д заасан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас заасан хязгаарт багтаан тогтооно.
 - 21.1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ хуулийн 20.1.5-20.1.8-д заасан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас заасан хязгаарт багтаан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Монгол Улсын Үндэсний татварын алба

22 дугаар зүйл. Үндэсний татварын албаны тогтолцоо
(Хуучин 19-р зүйл)

- 22.1. Үндэсний татварын алба нь Үндэсний татварын ерөнхий газар, түүний харъяа төвлөрсөн болон орон нутгийн төсвийн бүрдүүлэлтийг хангах үүрэг бүхий тусгайлсан татварын алба, аймгийн татварын хэлтэс (цаашид «Харъяа татварын алба» гэнэ), сумын татварын байцаагчаас бүрдэнэ. Орон нутгийн онцлогоос хамаарч сум дундын татварын тасаг ажиллуулж болно.
- 22.1.1. Үндэсний татварын алба бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.
- 22.1.2. Үндэсний татварын ерөнхий газар, түүний харъяа татварын албадад татварын хэрэг бүртгэх нэгж буюу хэрэг бүртгэгч ажиллана.
- 22.1.3. Үндэсний татварын ерөнхий газарт болон аймгийн татварын хэлтэст татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх эрх бүхий Татварын маргаан таслах зөвлөл ажиллана.

23 дугаар зүйл Татварын маргаан таслах зөвлөл
(Шинэ зүйл)

- 23.1 Татварын маргаан таслах зөвлөл нь (цаашид «Зөвлөл» гэнэ.) орон тооны бус байх бөгөөд үйл ажиллагаандаа энэ хуулиар тавигдаж байгаа шаардлагыг хангах, бусад хуулийг дээдлэх, татвар төлөгч татварын албаны эрх ашгийг адил түвшинд хамгаалах, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн нууцыг чандлан хадгалах зарчим баримталж ажиллана.
- 23.1.1. Зөвлөл нь дарга, гишүүн бүгд аймагт таваас, Үндэсний татварын ерөнхий газрын дэргэд долоогоос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэл, татвар, эдийн засаг, хуулийн болон бусад мэргэжлийн баклаераас доошгүй зэрэгтэй хүмүүс орсон байна. Татвар төлөгчдөөс зөвлөлийн гишүүнд төлөөлөгч ажиллуулж болно. Зөвлөл нь нарийн бичигтэй байна.
- 23.1.2. Тухайн маргаантай асуудлыг хариуцсан хэлтэс, тасгийн дарга, татварын байцаагч нь тухайн маргаан таслах зөвлөлд ажиллахгүй.
- 23.1.3. ҮТЕГ-ын дэргэдэх зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг татварын асуудал эрхэлсэн сайд аймгийн татварын хэлтсийн дэргэдэх зөвлөлийг ҮТЕГ-ын дарга томилно.
- 23.1.4. Аймгийн татварын хэлтсийн болон сумын татварын улсын байцаагчийн гаргасан шийдвэртэй холбогдсон гомдлыг тухайн аймгийн татварын хэлтсийн дэргэдэх зөвлөл, ҮТЕГ-ын ба түүний харъяа албаны татварын улсын байцаагчийн гаргасан

шийдвэртэй холбогдсон гомдлыг УТЕГ-ын дэргэдэх зөвлөл тус тус хүлээн авч, татварын хуульд нийцүүлэн хянаж шийдвэрлэнэ.

23.2. Зөвлөл нь дарах эрхийг эдэлнэ.

23.2.1. Маргааныг шийдвэрлэхдээ шаарлагатай бичиг баримт, тэдгээрийн хуулбар, материал, тооцоо, мэдээ судалгааг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, сан, иргэдээс гаргуулан авах

23.2.2. Гомдол гаргагч, хариуцагч болон холбогдох хүмүүсээс тайлбар, тодорхойлолт гаргуулж авах, санал хүсэлтийг нь сонсох

23.2.3. Мэргэжилтэн урьж зөвлөгөө авах, шаардлагатай тохиолдолд орчуулагч, шинжээч, магадлагч ажиллуулах, тэдэнд ажлын хөлс, замын болон томилолтын зардлыг татварын албаны төсвөөс олгуулах. Гэм буруутай нь тогтоогдвол олгосон зардлыг нэхэмжлэгчээс гаргуулан татварын албаны хөгжлийн санд төвлөрүүлэхээр гаргасан шийдвэртээ тусгах

23.2.4. Татварын алба, татварын улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг хууль зүйн үндэстэй гэж үзвэл татвар төлөгчийн гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгох, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүчингүй болгож, гомдол гаргагчид холбоотой актаар тавигдсан татвар, алданги, торгуулийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, түүндээ хураагдсан бараа, эд зүйлийг буцаан олгуулахаар хураагдсан бараа эд зүйл нь борлогдож, үнэ нь төсвийн орлого болсон бол үнийг буцаан олгохоор тус тус шийдвэрт тусгана.

23.2.5. УТЕГ-ын дэргэдэх татварын зөвлөл нь татвар төлөгчийн гомдлоор шаардлагатай тохиолдолд шууд шүүхэд хандаж болно.

23.2.6. Тухайн зөвлөлийн бүрэн эрх нь түүний шинэ бүрэлдэхүүн батлагдах өдөр хүртэл хэвээр байна.

23.3. Зөвлөл дараах үүргийг хүлээнэ.

23.3.1. Татвар төлөгчийн гомдлыг харъяаллын дагуу хүлээн авч шийдвэрлэх

23.3.2. Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг татвар төлөгч гомдол гаргагчид тайлбарлах

23.3.3. Аж ахуйн нэгж, байгууллага, сан, иргэдээс буцаан өгөхөөр авсан бичиг баримт, материалыг асуудал шийдвэрлэсний дараа нэн даруй буцаан өгөх, гэхдээ шаардлагатай бичиг баримтын хуулбарыг зөвлөлийн хурлын шийдвэрт хавсарган үлдээнэ. Зөвлөлийн шийдвэрийг татвар төлөгч зөвшөөрөхгүй бол шүүхэд хандахаар шийдвэрт тусгах.

24 дугаар зүйл

Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа (Шинэ зүйл)

24.1. Зөвлөл нь татвар төлөгчийн гомдлыг хүлээн авч, хуанлийн 30 хоногийн дотор шалгаж шийдвэрлэх ба энэ хугацаанд гомдлыг шалган шийдвэрлэх боломжгүй тохиолдолд зөвлөлийн дарга хугацааг нэг удаа хүртэл 60 хоногоор сунгаж болно.

- 24.2. Татвар төлөгчийн гаргасан гомдлын үндэслэлийг шалгаж дүгнэлт гаргаж хурлаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажилтныг зөвлөлийн дарга томилно. Шаардлагатай бол комисс, ажлын хэсэг байгуулж болно.
- 24.3. Зөвлөлийн хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэйгээр хийх ба олонхийн саналаар асуудлыг шийдэж тогтоол гаргана. Тогтоолд хуралд оролцсон зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурна. Тогтоол нь гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно. Шийдвэр гаргахад санал зөрүүтэй гишүүд байвал хурлын тэмдэглэлд өөрийн саналыг бичүүлнэ.
- 24.4. Зөвлөлийн шийдвэрийг татварын улсын байцаагч үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо дээд шатны зөвлөл буюу шүүхэд 14 хоногийн дотор гаргаж болно.
- 24.5. Зөвлөлийн даргын эзгүйд тухайн хурлын даргалагчийг тухайн хуралд оролцогч зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар томилно.
- 24.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн дотоод ажлыг хариуцах бгөөд хурлаар хэлэлцэх асуудлын бүрдлийг хангаж, хурлын тэмдэглэлийг хөтөлнө. Хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтөлж, хурлыг даргалагч болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж батална.
- 24.7. Татвар төлөгчийн гомдлыг маргаан таслах зөвлөл болон шүүхэд хүлээн авсан нь татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

25 дугаар зүйл

**Үндэсний татварын албаны дүрэм
(Хуучин 20-р зүйл)**

- 25.1. Үндэсний татварын албаны дүрмийг засгийн газар тогтооно.

26 дугаар зүйл

**Үндэсний татварын албаны удирдлагын
зарчим (Хуучин 21-р зүйл)**

- 26.1. Үндэсний татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.
- 26.2. ҮТЕГ татварын асуудал эрхэлсэн сайдын, ҮТЕГ-ын харъяа алба, аймаг дахь хэлтэс нь ҮТЕГ-ын, сумын татварын байцаагч нь аймгийн татварын хэлтсийн удирдлага дор ажиллана.
- 26.3. ҮТЕГ-ын дарга харъяа албадын даргыг, улсын байцаагчийг ҮТЕГ-ын дарга эрх олгосноор харъяа албадын дарга томилж чөлөөлнө.

27 дугаар зүйл

**Үндэсний татварын алба, татварын
байцаагч, татварын улсын байцаагч,
улсын ахлах байцаагчийн үйл
ажиллагааны зарчим (Хуучин 22-р зүйл)**

- 27.1. Үндэсний татварын алба, татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч нь үйл ажиллагаандаа хууль

дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн эрх ашгийг хүндэтгэх зарчим баримтална.

28 дугаар зүйл

**Үндэсний татварын албаны чиг үүрэг
(Хуучин 23-р зүйл)**

- 28.1. Үндэсний татварын алба дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 28.1.1. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 28.1.2. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал гаргах, сургалт, сурталчилгаа явуулах, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх;
- 28.1.3. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн татвараар орох орлогыг бүрдүүлэх, хуулийн хүрээнд ногдсон татварыг бүрэн хурааж төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг биелүүлэх.
- 28.2. Татварын хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн төсөл бэлтгэж санал өгөх.

29 дүгээр зүйл

**Үндэсний татварын алба, татварын
байцаагч, татварын улсын байцаагч,
улсын ахлах байцаагчийн бүрэн эрх**

- 29.1. Үндэсний татварын алба дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 29.1.1. Татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт үзүүлэх, түүнийг татвараас чөлөөлөх;
- 29.1.2. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй татвар төлөгчид хуульд заасан жишгээр татвар ногдуулах;
- 29.1.3. Татварын хэрэг бүртгэх ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу явуулах;
- 29.1.4. Тогтоосон хугацаанд татвар төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох;
- 29.1.5. Татварын албанаас тогтоосон төлбөл зохих татвар, алданги, торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол татвар хураах үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулах;
- 29.1.6. Илүү төлсөн татварыг дараачийн сар, улирал, жилийн татварт суутган тооцох буюу татвар төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эргүүлэн олгох;
- 29.1.7. Татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн, татварын мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй татвар төлөгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;
- 29.1.8. Доод шатны албаны гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

- 29.1.9. Татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;
- 29.1.10. Албан үүргээ гүйцэтгэхэд нь татварын улсын байцаагчид саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, түүнийг үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, амь бие, эрүүл мэндэд нь халдаж хохирол учруулсан гэм буруутай этгээдийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлэх;
- 29.1.11. Татварын өр төлбөрийг барагдуулах;
- 29.1.12. Татвар төлөгчдөөс хураах татварын жишиг тогтоох, татварын ногдлыг тусгайлан тогтоох. Энэ жишгээр татвар төлөгч нь татварыг төлж энэ талаар гомдол гаргахгүй;
- 29.1.13. Хууль тогтоомжид заасан бусад асуудал
- 29.2. Татварын улсын байцаагч нь дараах эрх эдэлнэ.
- 29.2.1. Өөрийн харъяалагдах татварын албаны харъяаны бүх татвар төлөгчдийн татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон данс бүртгэл, тайлан тэнцэл, төсөл, санхүүгийн баримт болон түүний аливаа хөрөнгөнд хяналт шалгалт хийх, асуулга явуулж, тайлбар лавлагаа гаргуулж авах
- 29.2.2. Татварын хяналт шалгалтанд шаардагдах магадлагаа, баримтын хуулбарыг татвар төлөгчийн харилцагч аливаа аж ахуйн нэгж, байгууллага, улсын болон орон нутгийн байгууллага, банк санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах.
- 29.2.3. Татвар ногдох зүйл нуусныг гэрчлэх баримтыг татвар төлөгчөөс түр хугацаагаар хураан авах, хуулбарлах
- 29.2.4. Орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйлийг хадгалж буй татвар төлөгчийн байр, агуулах (түүний байршлаас үл хамааран)-д нэвтрэн орж шалгалт тооллого, ажлын зураг авалт, шаардлагатай бол үзлэг хийх.
- 29.2.5. Татвар төлөгч бусдад шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч, төсөвт төлөөгүй бол түүнийг аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөнөөс нөхөн төлүүлэх
- 29.2.6. Татвар төлөгчид энэ хуулийн 15-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх.
- 29.3. Татварын байцаагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 29.3.1. Татварын улсын байцаагчийн ногдуулсан татвар, нөхөн татвар, торгууль, алданги төлөхийг татвар төлөгчөөс шаардах
- 29.3.2. Татвар төлөгчдөд мэдэгдэх хуудас гардуулах
- 29.3.3. Татварын улсын байцаагчийн ногдуулсан татвар, нөхөн татвар, торгууль, алдангийг барагдуулах зорилгоор татвар төлөгчийн аливаа хөрөнгөнд хяналт шалгалт хийх, асуулга явуулж, тайлбар лавлагаа гаргуулж авах
- 29.3.4. Орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйлийг хадгалж буй татвар төлөгчийн байр, агуулах (түүний байршлаас үл хамааран)-д нэвтрэн орж, шалгалт тооллого, ажлын зураг авалт, шаардлагатай бол үзлэг хийх.
- 29.4. Татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн нийтлэг үүрэг

- 29.4.1. Татвар төлөгчийн хөрөнгө, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний нууцыг чанд хадгалах
- 29.4.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад иргэн, аж ахуйн нэгж байгууллага хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа нь илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх.
- 29.4.3. Татварын хууль тогтоомжийг татвар төлөгчдөд сурталчлах, тэдэнд зохих үйлчилгээ үзүүлэх
- 29.4.4. Дээд шатны удирдах албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг бүрэн биелүүлж ажилдаа хэрэгжүүлэх
- 29.4.5. Төрийн алба, татварын албаны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, дэг журмыг сахиж, албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх.
- 29.4.6. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөнд автахгүй, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, татвар төлөгчийн эрх ашгийг хохироохгүй, шударга байх зарчмыг баримтлах.
- 29.4.7. Ажлын байрны тодорхойлолтоор заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- 29.5. Татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагчид хориглох зүйл;
 - 29.5.1. Татвар төлөгчийн тайлан тэнцэл гаргах.
 - 29.5.2. Татвар төлөгчийн зардлаар амралт сувилалд явах, гадаадад зорчих
 - 29.5.3. Татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн хооронд арилжаа худалдаа хийх, үйлчилгээ үзүүлэхээр зуучлах
 - 29.5.4. Татвар төлөгчөөс зээл тусламж авах, тэднээр үнэ хөлсгүй үйлчлүүлэх
 - 29.5.5. Татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч нь багшлах, эрдэм шинжилгээний ажил хийх, төрийн бус олон нийтийн байгууллагад орон тооны бус сонгуульт ажлаас бусад ажлыг давхар эрхлэхгүй байх.
 - 29.5.6. Татвар төлөгчийн нэрийн өмнөөс татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх ажлыг хөөцөлдөх
 - 29.5.7. Татварын орлогыг хувийн зорилгод ашиглах

30 дугаар зүйл. Үндэсний татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх

- 30.1. Монгол Улсын Засгийн газар үндэсний татварын ерөнхий газрын даргыг шууд, дэд даргыг үндэсний татварын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн томилно.
- 30.2. Үндэсний татварын ерөнхий газрын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 30.2.1. Татварын албаны бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд зохион байгуулалт, удирдлага, хяналтаар хангах;
 - 30.2.2. Татварын улсын байцаагчийн эрх олгох, цол, зэрэг олгох, эрхийг түдгэлзүүлэх;
 - 30.2.3. Татварын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөх тушаал гаргах;

- 30.2.4. Татварын бодлого боловсруулахад оролцох;
- 30.2.5. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээний төслийг боловсруулах, гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүргийг хангуулах;
- 30.2.6. Татварын улсын байцаагчийн гаргасан акт дүгнэлтийг хуулийн дагуу хянан үзэж өөрчлүүлэх, хүчингүй болгох;
- 30.2.7. Үндэсний татварын албаны удирдах болон ерөнхий газрын ажилтнуудыг томилох, чөлөөлөх;
- 30.2.8. Татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаад ёс зүйн дүгнэлт өгөх;
- 30.2.9. Үндэсний татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах
- 30.2.10. Татвар төлөгч иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон иргэний татварыг төлөх үүрэг нь шилжих өв залгамжлагч байхгүй, тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон, хөөн хэлэлцэх хугацаа дууссан өрийг хүчингүй болгох буюу шүүхээр хүчингүй болгуулах;
- 30.2.11. Татварын хуулийн аливаа заалт буруу болсныг эрхэлсэн сайдад мэдэгдэх;
- 30.2.12. Татварын байцаагчийн болон хэрэг бүртгэх эрх олгох;
- 30.2.13. Татварын байцаагчид зэрэг олгох журам батлах;
- 30.2.14. Энэ зүйлийн 2.1-2.13-т тусгагдсан эрхүүдийг харьяа татварын албадын дарга нарт шилжүүлэх.
- 30.3. ҮТЕГ-ын даргын эзгүйд түүний бүрэн эрхийг дэд дарга гүйцэтгэнэ.

31 дүгээр зүйл**Үндэсний татварын албаны төсөв
(Хуучин 27 дугаар зүйл)**

- 31.1. Үндэсний татварын албыг төвлөрсөн төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.
- 31.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлага нь өөрийн нутаг дэвсгэрт байгаа татварын албанд шаардлагатай эзэмшлийн газар олгож, холбоо, эрчим хүч, дулаанаар саадгүй үйлчилж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцлөөр хангана.

32 дугаар зүйл**Татварын албаны хөгжлийн сан**

- 32.1. Татварын албаны ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, албаны сургалтын болон материаллаг байдлыг бэхжүүлэх, ажилтнуудыг урамшуулах зорилгоор татварын алба хөгжлийн сантай байна.
- 32.2. Татварын албаны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн үндсэн эх үүсвэр нь татварын хяналт шалгалтаар ногдуулсан нөхөн төлбөр, торгууль, алдангаар олсон орлогын 20% нь байна.
- 32.3. Сангийн орлогын эх үсвэрийг эрхэлсэн сайд батална.

33 дугаар зүйл Сангийн хөрөнгийн зарцуулалт (Шинэ зүйл)

- 33.1. Сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна.
 - 33.1.1. Үндэсний татварын албаны материаллаг баазыг бэхжүүлэхтэй холбогдуулан албан ажлын байр барих ба худалдан авах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах нэмэгдэл зардлыг бэхжүүлэх
 - 33.1.2. Албанд ажиллагсдын мэргэжил мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, дадлагажуулах зорилгоор тэднийг гадаад додоодын сургалт, хурал семинарт оролцуулах
 - 33.1.3. Ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах, ая тухтай амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх үүднээс тэдэнд зориулан орон сууц бариулах, худалдан авах
 - 33.1.4. Тэргүүний татвар төлөгчид, татварын албад болон байцаагчдыг шагнаж урамшуулах
 - 33.1.5. Татварын улсын байцаагчид, татвар хураагч нарт зориулсан ном, гарын авлага бэлтгэх, худалдан авах
- 33.2. Хөгжлийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн жилд шилжүүлэн зарцуулна.

34 дүгээр зүйл Татварын улсын байцаагчийн ангилал, шагнал, шалгалт авах журам

- 34.1. Татварын албанд татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч, татварын ерөнхий байцаагч ажиллана. Татварын улсын байцаагч, татварын ерөнхий байцаагч нь хувийн тэмдэгтэй байна.
- 34.2. Татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч, татварын ерөнхий байцаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин, нэмэгдэл авахдаа Төрийн албаны тухай хуулийг баримтална.
- 34.3. Татварын улсын байцаагч, татварын ерөнхий байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгоно. Сар тутам олгох ажлын үр дүнгийн шагналын нийлбэр нь эдгээрийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 34.4. Ажлын үр дүнгийн шагнал олгох журмыг Үндэсний татварын ерөнхий газар тогтооно.
- 34.5. Татварын байцаагчид олгох шагналыг Төрийн албаны тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 34.6. Татварын улсын байцаагчийн эрх олгох шалгалтыг 4 жилд 1 удаа, зэрэг тогтоох шалгалтыг 2 жилд 1 удаа тус тус авна. Энэ заалт улсын ерөнхий ба ахлах байцаагчид хамаарахгүй.

35 дугаар зүйл Татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагчид хүлээлгэх хариуцлага (Хуучин 25-р зүйл)

- 35.1. Татвар төлөгчийн хууль бус үйл ажиллагааг нуух, татварын орлогыг хувийн зорилгод ашиглах, мэдээлийн нууцыг задруулах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй татварын байцаагч, татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагчид хууль тогтоомжид заасан сахилгын, захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- 35.1. Татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага:
- 35.1.1. Татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч нь Төрийн захиргааны албан хаагчийн тангараг зөрчсөн буюу албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, эрх хэмжээгээ хэтрүүлсэн, хуулиар хориглосон заалтыг зөрчих зэргээр хариуцлага сахилга алдсан тохиолдолд гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах сахилгын хариуцлагыг ногдуулна:
- 35.1.1.1. Сануулах;
- 35.1.1.2. Төрийн албаны зэрэг, дэвийг бууруулах буюу хасах;
- 35.1.1.3. Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хувь хүртэл хэмжээгээр бууруулах;
- 35.1.1.4. Улсын байцаагчийн зэрэг бууруулах эсвэл цол хасах;
- 35.1.1.5. Татварын албанаас халах;
- 35.1.1.6. Гаргасан зөрчил нь гэмт хэргийн шинж бүхий үйлдэл байвал татварын албанаас халж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын мэдэлд шилжүүлэх.

36 дугаар зүйл

Татварын албаны ажилтны эрхийн баталгаа (Хуучин 28-р зүйл)

- 36.1. Татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч, татварын ерөнхий байцаагч дүрэмт хувцас үнэ төлбөргүй хэрэглэнэ. Татварын улсын байцаагч, улсын ахлах байцаагч, татварын ерөнхий байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.
- 36.2. Татварын албаны ажилтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон, бусдын нөлөөгөөр амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дараахь буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг олгоно.
- 36.2.1. хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүү;
- 36.2.2. тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүү;
- 36.2.3. хиймэл эрхтэн хийлгэх тохиолдолд түүнийг зардал;
- 36.2.4. эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын зардлаас хэтэрсэн зардал;

- 36.2.5. хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тохиолдолд албан тушаалын 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;
- 36.2.6. өндөр насны тэтгэвэрт гаргасан тохиолдолд 6 сарын дундаж цалин, хөлстэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж;
- 36.2.7. амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж.
- 36.3. Энэ зүйлийн 2.7 дахь хэсэгт заасан буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг төсвөөс олгож, уг хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

37 дугаар зүйл

Татварын албаны удирдах ажилтны цол

- 37.1. Үндэсний татварын ерөнхий газрын удирдах ажилтнууд нь дараах цолтой байна.
 - 37.1.1. Үндэсний татварын албаны жинхэнэ зөвлөх;
 - 37.1.2. Үндэсний татварын албаны итгэмжит зөвлөх.
- 37.2. Харьяа албад ба орон нутаг дахь хэлтсийн дарга нь татварын албаны 1, 2, 3 дугаар зэргийн зөвлөх.
- 37.3. Татварын бодлогын жинхэнэ зөвлөх, итгэмжит зөвлөх цолыг эрхэлсэн сайдын тушаалаар, Татварын албаны 1, 2, 3 дугаар зэргийн зөвлөх цолыг Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.
- 37.4. Цол олгох журмыг эрхэлсэн сайдын тушаалаар батлана.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТАТВАРЫН ИТГЭМЖЛЭГДСЭН НЯГТЛАН БОДОГЧ**

38 дугаар зүйл *Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулах*

- 38.1. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газарт татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулна.
- 38.1.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь Татварын албанд бүртгүүлэн шалгалт өгч, зөвшөөрөл авсан байна.
- 38.1.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч бүхий татвар төлөгчийг найдвартай татвар төлөгчид хамруулах нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзнэ.
- 38.1.3. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татвар төлөгчийн хувьд мөрдөгдөж байгаа татварын хуулиудын хүрээнд татварын ногдлыг үнэн зөв хийж ногдсон татварыг хугацаанд нь төлүүлж хууль зөрчснөөс хүү, торгууль хүлээхээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн алдагдалд орохоос хамгаалах зорилготой ажиллана.
- 38.1.4. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татварын албаны хувьд татварын хуулийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх хуульд заасан хугацаанд татварын төлбөр хийлгэх хууль зөрчигдөхөөс сэргийлэх, татварын ногдол хийх арга зүйгээр татвар төлөгчийг хангах зорилготой ажиллана.
- 38.1.5. Татварын нэг итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын тооцоог баталгаажуулж болно.

39 дугаар зүйл *Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах ажилтанд зөвшөөрөл олгоход тавих шалгуур*

- 39.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах зөвшөөрөл авах ажилтан нь нягтлан бодох бүртгэл, санхүү эдийн засгийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү төлбөр тооцооны ажлыг ажлын байранд тавигдаж буй шаардлагын хэмжээнд мэддэг, ажлын дадлага туршлагатай, татварын хууль тогтоомжийн талаар татварын албанаас тавьж буй шаардлагыг хангасан мэдлэгтэй, цаашид тогтвор суурьшилтай ажиллах хүсэл сонирхолтой хүн байна.
- 39.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах ажилтан нь санхүүгийн болон өртгийн бүртгэл, аудит, менежментийн зөвлөгөө өгөх чадвартай, татварын тайланг гаргах, санхүүгийн болон татварын тайлангийн зөрүүг тооцох, татварын ногдол хийх арга зүйг эзэмшсэн байна.

39.3. Татварын итгэмжлэгдсэн нягтдан бодогч нь баклаварын болон түүнээс дээш боловсролын түвшинтэй байна. Харин мэргэшсэн нягтлан бодогч бол боловсролын түвшингийн шалгуурт хамаарахгүй.

40 дүгээр зүйл. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвшөөрөл олгох шалгалт

40.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвшөөрөл олгох шалгалт нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч болоход шаардлагатай мэдлэгтэй эсэх, түүнийг хэрэгжүүлэх чадварыг тогтоох зорилготой байна.

40.1.1. Мэргэжлээрээ ажилласан байдал, санхүү бүртгэлийн алдаа дутагдал урьд өмнө гаргаж байсан эсэхийг шалгалтын комисс магадлан тогтоож шалгалтанд орох зөвшөөрөл олгоно.

40.1.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах зөвшөөрөл авах этгээд нь татварын хуулиудаар болон нягтлан бодох бүртгэл, практик дадлагын шалгалт өгнө. Шалгалт өгөх хуулиудын жагсаалтыг Үндэсний татварын ерөнхий газраас гаргана.

40.1.3. Шалгалтын асуулт, дадлагын чадварыг тогтоох тестийн агуулгыг Үндэсний татварын ерөнхий газар гаргана.

41 дүгээр зүйл Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах зөвшөөрөл олгох шалгалтын комисс

41.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах зөвшөөрөл олгоход тавигдсан шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох зорилго бүхий шалгалтын комисс ҮТЕГ-т ажиллана.

41.1.1. Комиссын бүрэлдэхүүнийг Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар батална.

41.1.2. Комисс нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангаж буй эсэхийг тодорхойлсон шалгалтыг авч зөвшөөрөл олгох талаархи саналаа ҮТЕГ-ын даргад гаргана.

41.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох

41.2.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад дараах бичиг баримтыг Үндэсний татварын ерөнхий газарт буюу аймгийн татварын хэлтэст ирүүлнэ;

41.2.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллахыг хүссэн өргөдөл;

41.2.3. Мэргэжлийн дипломын хуулбар;

41.2.4. Мэргэшсэн нягтлан бодогч бол мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний хуулбар;

41.2.5. Намтар

- 41.2.6. Шалгалтанд орохыг зөвшөөрсөн холбогдох татвар, санхүүгийн байгууллагын тодорхойлолт.
- 41.3. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг шалгалт бүрт 75 хувиас дээш оноо авсан хүнд шалгалт дууссанаас хойш 14 хоногт багтаан ҮТЕГ-ын даргын тушаалаар олгоно.
- 41.3.1. Зөвшөөрлийг жил тутам шинэчлэн олгоно.
- 41.3.2. Зөвшөөрөл авсанаас хойш нэг улирлын дотор үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд тухайн зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 41.3.3. Татварын хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал нь түүний баталгаажуулсан татварын ногдол, тайлантай холбоотой бол түүнд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 41.3.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөвшөөрлийн хугацаа дууссан зөвшөөрөл сунгах шалгалтанд тэнцээгүй тохиолдолд ҮТЕГ-ын даргын тушаалаар хүчингүй болгож нийтэд зарлана.

42 дүгээр зүйл. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдод татварын албаны зүгээс үзүүлэх туслалцаа

- 42.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдод татварын талаар мэдлэг олгох сургалтын программ гаргаж түүний дагуу сургалтыг оны эхэнд баталсан хуваарийн дагуу явуулж түүнд тэднийг үнэ төлбөргүй хамруулж, мэргэшүүлэх арга хэмжээ авна.
- 42.1.1. Татварын тайлан тооцоог үнэн зөв хийж, татварын хуулийг хэрэгжүүлэхэд санаачлагатай ажилласан тухайн татвар төлөгчийг татварын зөрчилгүй ажиллах боломжийг бүрдүүлсэн итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг түүний улирлын цалингийн 30 хүртэл хувиарь шагнаж урамшуулахаар тухайн татвар төлөгчид тодорхойлно.
- 42.2. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг татвар төлөгчид дараах нөхцлөөр хангаж өгнө.
- 42.2.1. Татварын ногдол хийхэд шаардагдах татвар ногдох орлого болон татвар ногдуулах орлогыг тодорхойлоход гарсан зардлыг нотлох анхан шатны баримтаар цаг тухайд нь хангах;
- 42.2.2. Татварын төлөлтийн талаархи мэдээллийг татварын нэр төрлөөр нь гарган өгөх;
- 42.2.3. Татварын ногдуулалт, төлөлтийн талаархи программ хангамжийн талаар байнгын мэдээлэлтэй байх боломжоор хангагдах;
- 42.2.4. Бүртгэл, санхүү, татварын тайлангийн маягт, шаардлагатай техник хэрэгсэл, хууль тогтоомж, дүрэм, заавар бусад гарын авлага материалаар цаг тухайд нь хангана;
- 42.2.5. Татварын албанаас тавьсан шаардлагыг цаг тухайд нь хэрэгжүүлэх боломжтой байх;
- 42.2.6. Гэрээгээр тохиролцсон бусад нөхцлөөр хангах.
- 42.3. Татварын алба татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг дараах нөхцлөөр хангаж өгнө.
- 42.3.1. Татварын ногдуулалт хийх талаар арга зүйн туслалцааг үнэ төлбөргүй буюу төлбөртэй авах;

- 42.3.2.Татварын хууль тогтоомж, аргачлалыг тэргүүн ээлжинд үнэ төлбөргүй буюу төлбөртэй авах;
- 42.3.3.Тухайн татвар төлөгчийн төлсөн татварын талаархи шаардагдах мэдээллийг гарган өгөх;
- 42.3.4.Татварын тайланд орсон өөрчлөлтийн талаар тэргүүн ээлжинд мэдээлэл өгөх;

43 дугаар зүйл

Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхлэх үйл ажиллагаа

- 43.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татвар төлөгчийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.
 - 43.1.1. Татварын ногдлыг татварын төрөл тус бүр дээр хийж хуулиар тогтоосон хугацаанд төлүүлэхээр удирдлагад мэдэгдэх;
 - 43.1.2.Татварын тайлангийн үнэн зөв эсэхийг шалган тогтоож тайланг тогтоосон хугацаанд нь харъяалах татварын албанд тушаалгах;
 - 43.1.3. Ногдсон татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хожимдуулсны хүүг тооцон төлүүлэх арга хэмжээг авахуулах;
 - 43.1.4. Хүн амын орлогын албан татварын суутгалын тооцоог шалган иргэний орлого татвар тодорхойлох хуудсаар тооцоо хийлгэх ажлыг зохион байгуулах;
 - 43.1.5. Татвар төлөгчийн татварын тайланг шалган баталгаажуулж харъяалах татварын албанд тушаалгана.
- 43.2. Татварын албаны хувьд татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.
 - 43.2.1.Өөрийн баталгаажуулсан татварын тайланг хуульд заасан хугацаанд тухайн татварын албанд тушаалгах;
 - 43.2.2.Татварын баримт бичилтийн журмын дагуу татвар төлөлтийн баримт бичигдэж байгаа эсэхэд хяналт тавьж энэ журмыг мөрдөн ажиллууна.
 - 43.2.3.Татварын орлогын сар улирлын хуваарийг татвар төлөгчийн санал болгосноор гарган харьцагч татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж батлуулан мөрдүүлнэ.
 - 43.2.4.Татварын илүү, дутуу төлөлтийн тооцоог гарган суутган тооцох, буцаан олгох талаархи саналаа тавьж шийдвэрлүүлнэ.

44 дүгээр зүйл

Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн хүлээх үүрэг

- 44.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мэдэж авсан нууцыг шалтгаангүйгээр задруулах буюу ашиглаж үл болно.
 - 44.1.1.Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хүлээлгэсэн итгэл найдварыг хөсөрдүүлэхгүй ажиллах үүрэгтэй.
 - 44.1.2.Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь өөрөө болон татвар төлөгчөөр татвараа буруу тодорхойлох, татвараас зайлсхийх,

шудрага бус замаар татвар буцаан авах зөвлөгөө өгөх үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

45 дүгээр зүйл *Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулснаас гарах үүдлийн төлөө үүрэг хүлээхгүй байх нөхцлүүд*

45.1. Татварын алба нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн хууль зөрчсөн аливаа үйлдлийн төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй

46 дугаар дугаар зүйл *Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд тавих хяналт*

46.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд ажиллуулж байгаа болон итгэмжилсэн зөвшөөрөл өгсөн харъяалах татварын алба тэдгээрийн удирдлага хамтын хяналт тавьж ажиллана.

46.1.1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлтийг хоёр тал тус бүр дараа улирлын эхний сарын 20-ны дотор гарган цаашид ажиллуулах, урамшуулал олгох эсэх талаар харилцан мэдээлэл солилцоно.

46.1.2. Татварын алба нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд түүний баталгаажуулсан татварын тайлан, ногдлыг болон тухайн тайланг шалгах явцдаа хяналт тавина.

46.1.3. Татварын итгэмжлэгдсэн нягтдан бодогчоор ажиллах зөвшөөрөл авсан этгээд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа эсэхэд аймгийн татварын хэлтэс болон Үндэсний татварын албаны харъяа албад хяналт тавина.

**ТАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

47 дугаар зүйл *Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үүрэг*

47.1. Төрийн захиргааны төв, орон нутгийн болон хууль хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан татварын хяналтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.

47.2. Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан татварын ногдуулалт, хураалт, хяналт шалгалт хийх,

хэрэг бүртгэх, судалгаа хийхэд шаардлагатай аливаа мэдээ, судалгаа, тоо, баримтыг уг ажлыг гүйцэтгэж буй татварын улсын байцаагчид тухайн хэлтэс, газрын даргын гарын үсэгтэй албан тоотыг үндэслэн харилцан тохиролцсон мэдээлэл солилцох журмын дагуу үнэ төлбөргүйгээр гарган өгч, шаардлагатай бол хамтран ажиллаж байна.

48 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох (Хуучин 30-р зүйл)

48.1. Энэ хуулийг 2001 оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хавсралт 3

**ТАТВАР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ,
ТАТВАР ХУРААХ ТУХАЙ
(хуулийн төсөл)**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж

- 2.1. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Татварын ерөнхий хууль, татварын хуулиуд, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Татварын алба, байцаагчийн хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах зарчмыг хангах

- 3.1. Үндэсний татварын алба /цаашид «Татварын алба» гэх/, байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.
- 3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан нь татварын алба, байцаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 3.3. Татварын алба, байцаагчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хууль тогтоомжоор эрх олгосноос бусад иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шийдвэр гаргахыг хориглоно.
- 3.4. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээж болохгүй.

4 дүгээр зүйл. Татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг хангах

- 4.1. Татварын алба, байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

- 4.2. Татварын алба, байцаагч хуульд заасны дагуу татварын ногдлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд үл оролцоно.
- 4.3. Татварын алба болон байцаагч, татварын албаны бусад албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар тодорхойлсон татвар төлөгчийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд зөвхөн төрийн байгууллагын дор дурдсан албан тушаалтанд Татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно.
 - 4.3.1. Татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын албаны бусад байцаагч, албан тушаалтан
 - 4.3.2. Татварын хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулж байгаа болон прокурорын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд уг зөрчилд нь холбогдох асуудлаар
 - 4.3.3. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу бусад орны татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтан
- 4.4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд татвар төлөгчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн түүний тухай мэдээ, баримтыг бусдад танилцуулж болно.
- 4.5. Татварын алба татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татварын үйл ажиллагааг нь сурталчлахыг татвар төлөгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд татвар төлөгчийн тухай нийтэд мэдээлэх эрхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Татварын албанаас татвар төлөгчтэй харилцах

5 дугаар зүйл. Татвар төлөгчийг бүртгэх

- 5.1. Татвар ногдох орлого бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон бусдад олгосон орлогод ногдох татварыг суутган авагч этгээд нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үйл ажиллагаагаа эрхэлж эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө Татварын албанд бүртгүүлнэ.
- 5.2. Орлогоос бусад татвар ногдох зүйл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол уг зүйлийг эзэмшиж эхэлснээсээ хойш нэг сарын дотор Татварын албанд бүртгүүлнэ.
- 5.3. Татварын алба нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон татвар суутган авагч этгээдийг татварын төрөл тус бүрээр бүртгэн, татвар төлөгч бүрд нэг регистрийн дугаар олгож, хувийн хэрэг нээнэ. Татвар төлөгчид хувийн хэрэгт хавсаргах дараах зүйлсийг тусгасан баримт материалыг бүрдүүлнэ.

- 1) Татвар төлөгчийн регистр гэрчилгээний дугаар, удирдлагын овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар
 - 2) Татвар төлөгчийн оршин суугаа хаяг, гишүүд ажилчдын тоо, утасны дугаар, удирдлагын гишүүдийн товч анкет, зураг, иргэний үнэмлэхийн дугаар
 - 3) Аж ахуйн нэгжийн байгуулагдсан он сар өдөр, үйл ажиллагааны чиглэл хэлбэр
 - 4) Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, газар эзэмшлийн байдал, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө зэргийг тусгасан баталгаажсан тайлангийн хуулбар
 - 5) Хөрөнгө оруулагчид болон харъяа салбар нэгжийн нэр, тоо, тэдгээрийн байршил, хаяг утас
 - 6) Санхүүгийн удирдлага зохион байгуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт, татварын тайлан гаргадаг ТИНБ-ийн овог нэр, хаяг, утас
 - 7) Гэрээт татварын мэргэжсэн нягтлан бодогчийн овог нэр, хаяг, утас
 - 8) Дүрмийн сангийн хэмжээ, түүний өссөн буурсан байдал, гол харилцагч газруудын нэр, хаяг
- 5.4 Татвар төлөгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх тухай бүрд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор энэ тухайгаа татварын албанд мэдэгдэж, бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэнэ.
- 5.5 Татварын төрлөөр олгосон регистрийн дугаарыг татвар төлөгч, татвар суутган авагч аливаа этгээд татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн болон бусад шаардлагатай баримтуудад бичнэ. Татвар төлөгч нь байнгын регистрийн дугаараа өөрийн харилцагчид мэдээлж байх үүрэгтэй. Мөн татвар суутган авагч этгээдэд бүртгэлийн дугаар олгох журмыг УТЕГ батална.
- 5.6 Үл хөдлөх хөрөнгийг бусад худалдах, худалдан авах, шилжүүлэх, бэлэглэх болон түүнээс бусад хэлбэрээр шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд татвар төлөгч нь харъяалагдах татварын албанд энэ тухайгаа 20 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 5.7 Аливаа татвар төлөгч нь харилцагч татварын байгууллагаа солихдоо тухайн төсвийн жил дууссаны дараа ямар нэгэн татварын өргүй тохиолдолд хийж болно. Татвар төлөгч татварын өртэй бол түүний шилжилт хөдөлгөөнийг хийхгүй бөгөөд шилжилт хийлгэх татвар төлөгч нь өөрийн хувийн хэрэг болон орлого татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийлгэж, зохих татварын тооцоог хийж барагдуулна.

6 дугаар зүйл. Татвар төлөгчдөд үйлчлэх

- 6.1. Татварын алба, байцаагч хууль тогтоомжоор тодорхойлогдсон татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь татвар төлөгчдөд туслах зорилгоор дараахь үйлчилгээг үзүүлнэ.
 - 6.1.1. татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулах
 - 6.1.2. татварын хууль тогтоомжийг нэг мөр дагаж мөрдөх, татварын үүргийг тодорхойлох, тайлан мэдээ гаргахтай холбогдсон заавар, аргачлал, гарын авлага, маягтаар хангах
 - 6.1.3. татварын үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар татвар төлөгч хэсгээрээ буюу ганцаарчлан зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх

7 дугаар зүйл. Татварын алба, татварын улсын байцаагчийн шийдвэр, татвар төлөгчтэй харилцахад үйлдэх баримт бичиг

- 7.1. Татварын алба, байцаагчаас татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, дүгнэлт, гэрээ, тэмдэглэл үйлдэнэ. Татварын алба, байцаагчийн хууль ёсны мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, дүгнэлт, гэрээ, тэмдэглэлд тавигдсан шаардлагыг татвар төлөгч биелүүлэх үүрэгтэй.
- 7.2. Татварын алба, байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-4-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичнэ. Мэдэгдэлд түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, шаардлага биелүүлэх хугацаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана.
- 7.3. Татварын алба, байцаагч нь татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу ногдох татварыг тодорхойлох, Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэхэд акт үйлдэнэ. Актад түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэслэл, гардуулсан он, сар, өдрийг тусгана.
- 7.4. Татварын алба, байцаагч нь татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулах зорилгоор шаардлага бичнэ. Шаардлагад түүнийг бичсэн он, сар, өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж хариу өгөх хугацаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана.
- 7.5. Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй болон жишгээр ногдуулсан татварын ногдлыг төлүүлэхээр мэдэгдэх хуудас бичнэ. Мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулах бол энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, татвар төлөгчийн харилцагч банкинд өгөх бол энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу уг хуудсыг үйлдэнэ.
- 7.6. Цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулах бол татвар суутган авагч этгээдэд төлбөрийн хуудас бичнэ. Төлбөрийн хуудсанд татварын төлбөрийг хүлээн авах газрын нэр, хаяг, бичсэн он, сар,

- өдөр, Татварын алба, байцаагчийн нэр, татвар төлөгчийн хаяг, төлөх татварын хэмжээ, гардуулсан он, сар, өдөр, хариу мэдэгдэх хугацааг тусгана.
- 7.7. Татварын алба, татварын улсын байцаагч татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсвэл татвар ногдох их хэмжээний орлого нуусан, татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэгт бүртгэл хийлгэхээр дүгнэлт бичнэ. Дүгнэлтэд түүнийг бичсэн он, сар, өдөр, эрүүгийн хэрэг үүсгүүлэх болсон зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчлийг баталж байгаа баримтууд, татварын алба, татварын улсын байцаагчийн нэр болон холбогдогч этгээдийн тайлбар, дүгнэлтийг түүнд танилцуулсан он сар өдрийг тусгана.
- 7.8. Татварын алба, татварын улсын байцаагч татварын өр төлбөрийг барагдуулах зорилгоор татвар төлөгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгийг барьцаалахдаа Иргэний хуулийн 181-р зүйлд заасны дагуу гэрээ байгуулна. Гэрээнд барьцаалах эд хөрөнгийн үнэ, хэлбэр, өнгө, нэр, барьцаалах хугацаа, хариуцлага зэргийг зааж, он сар өдрийг тэмдэглэн, хоёр тал гарын үсэг зурснаар хүчинтэй болно.
- 7.9. Татварын улсын байцаагч нь бүрэн эрхийн хүрээнд татвар төлөгчийн албан байр, сав, агуулах, хашаа, гаражид үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хураах болон татвар төлөгчтэй ярилцах, асуулга хийхдээ тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд татварын алба, татварын улсын байцаагчийн нэр, татвар төлөгчийн хаяг, явуулсан ажиллагаа, ярилцлагын агуулга, асуулт хариулт, он сар өдрийг тодорхой тусгаж тэмдэглэл үйлдэхэд байлцсан хүмүүс гарын үсэг зурна.
- 7.10. Татварын алба, байцаагчийн мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх болон төлбөрийн хуудсыг татвар төлөгчид биечлэн гардуулсан буюу тэдгээрийн оршин байгаа, эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар шуудангаар хүргүүлснийг дээрх мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх болон төлбөрийн хуудсыг зохих татвар төлөгчид өгсөнд тооцно. Оршин байгаа буюу ажиллаж байгаа газрын хаяг нь хуулийн этгээд буюу иргэний бүртгэлийг хөтлөх байгууллагад хамгийн сүүлд бүртгүүлсэн хаяг байна.

8 дугаар зүйл. Татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах

- 8.1. Татвар төлөгч нь хууль тогтоомжийн дагуу татвар ногдох зүйл, төлөх татварын хэмжээг тодорхойлохтой холбогдсон баримтыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын тухайд нягтлан бодох бүртгэл, иргэний тухайд энгийн бүртгэл хөтөлнө.
- 8.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг гадаад хэл дээр үйлдсэн бол татвар төлөгч түүнийг монгол хэл дээр орчуулж өгөх үүрэг хүлээнэ. Ийнхүү оруулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч хариуцна.
- 8.3. Татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээд нь уг баримт, бүртгэлийг татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгална.

9 дүгээр зүйл. Татварын тайлан гаргах, тушаах, баталгаажуулах

- 9.1. Татвар төлөгч татварын тайлан, татвар тодорхойлох хуудас /цаашид «татварын тайлан» гэх/-ыг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу гаргаж, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор баталгаажуулан харьяалагдах Татварын албанд тушаана.
- 9.2. Хууль тогтоомжийн дагуу татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамаарагдах татвар төлөгч нь татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй. Хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх эсэхийг татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн гарын үсэгтэй татварын тайланг үндэслэн шийдвэрлэнэ.
- 9.3. Итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татварын ерөнхий газрын шалгалтанд тэнцэж, татварын ерөнхий газрын даргын тушаалаар татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан тодорхой эрх бүхий албан тушаалтан байна. Итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хэд хэдэн аж ахуйн нэгж байгууллагын тайланг баталгаажуулж болно.
- 9.4. Татварын тайланд аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч болон татвар төлөгч иргэн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна.
- 9.5. Татвар төлөгчийн татварын тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд татварын тайланд гарын үсэг зурна. Хариуцсан үүргийнхээ дагуу татварын тайланг гаргахад хэд хэдэн албан тушаалтан оролцдог бол татварын тайланд ерөнхий, ахлах нягтлан бодогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гарын үсэг зурна.
- 9.6. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч Татварын албанд бүртгүүлэн, шалгалт өгсөн байна. Татварын нэг итгэмжлэгдсэн нягтлан бодогч хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын тооцоог хийхэд оролцож болно.
- 9.7. Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь энэ тухай баримтыг уг зүйлийг шилжүүлэн авсан этгээдэд тухай бүр, Татварын албанд шаардсан үед гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

10 дугаар зүйл. Татварын алба, татварын улсын байцаагч мэдээ, баримт цуглуулах, шалгалт хийх

- 10.1. Татварын алба болон татварын улсын байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3-д заасан үйл ажиллагааг явуулж, татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураахтай холбогдсон мэдээ, баримт цуглуулахдаа дараахь журмыг баримтална.
 - 10.1.1. татварын улсын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааныхаа зорилгыг тайлбарлах
 - 10.1.2. аливаа баримт, мэдээ, материалыг түр хугацаагаар хураан авах, хуулбарлахдаа хөндлөнгийн гэрч, эсвэл татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг байлцуулан тэмдэглэл үйлдэж, тэднээр гарын үсгийг зуруулах

- 10.1.3. нотолгооны чанартай бичиг баримтын гэрэл зургийг авах, дүрс бичлэг хийх
- 10.1.4. тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах
- 10.1.5. татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураах, хяналт шалгалт хийхтэй холбогдсон мэдээ, баримтыг татвар төлөгч болон холбогдох этгээдээс шаардах
- 10.2. Татварын улсын байцаагч шаардлагатай мэдээ, баримтыг хуулбарлан авахдаа бусдын техник хэрэгслийг ашигласан бол ашигласны хөлсийг зах зээлийн үнээр, эсхүл харилцан тохиролцсон үнээр төлнө.

11 дүгээр зүйл. Байр, агуулахад нэвтрэн орох журам

- 11.1. Татварын алба болон татварын улсын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасан орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татварын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг хадгалж байгаа татвар төлөгчийн нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээний болон албан байр, агуулах, зооринд урьдчилан мэдэгдэхгүйгээр нэвтрэн орж шаардлагатай ажиллагааг явуулна.
- 11.2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь гадаад орны дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын дипломат эрх бүхий албан тушаалтны ажлын байр, агуулахад хамаарахгүй.

12 дугаар зүйл. Үзлэг хийх журам

- 12.1. Татварын алба, татварын улсын байцаагч нь татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураах зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасны дагуу үзлэг хийхдээ дараах журмыг баримтална.
 - 12.1.1. Үзлэг хийхэд татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, эсвэл хөндлөнгийн гэрч байлцуулна.
 - 12.1.2. Үзлэг хийх ажиллагаанд үзлэгт хамрагдаж байгаа байр, агуулах, хадгалах, тээвэрлэх, зөөвөрлөх сав хэрэгсэл эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол зохих нутгийн захиргааны төлөөлөгчийг байлцуулна. Үзлэг хийхэд шаардлагатай бол татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг оролцуулж болно.
 - 12.1.3. үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Үзлэг хийхэд оролцсон, байлцсан бүх хүмүүс тэмдэглэлд гарын үсэг зурна. Үзлэгт оролцогчид, байлцсан хүмүүс гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож тайлбарыг тэмдэглэлд бичнэ.

- 12.2. Үзлэгт хамрагдах зүйл нь хэний эзэмшилд байгаагаас үл хамаарч үзлэгийг хийнэ.

13 дугаар зүйл. Тооллого явуулах журам

- 13.1. Татварын алба, татварын улсын байцаагч нь шаардлагатай тохиолдолд татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, энэ хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд тооллого хийхдээ дараахь журмыг баримтална.
- 13.1.1. бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгө, үнэт цаасны тооллогыг татвар төлөгч буюу түүний хууль ёсны төлөөлөгч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, эсвэл тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулан хийж тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэнэ.
- 13.1.2. тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого явуулсан татварын байцаагч, татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна. Татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч тооллогын бүртгэлд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож тэмдэглэл үйлдэн тооллогын бүртгэлд хавсаргана.

14 дүгээр зүйл. Ажлын зураг авалт хийх журам

- 14.1. Татварын алба, татварын улсын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, энэ хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд ажлын зураг авалт хийхдээ дараахь журмыг баримтална.
- 14.1.1. Татвар төлөгчийн зөвхөн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлохын тулд татвар төлөгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийнэ.
- 14.1.2. Ажлын зураг авалтыг татвар төлөгчид урьдчилан мэдэгдэх буюу мэдэгдэхгүйгээр хийж болно. Ажлын зураг авалт хийх тухай урьдчилан мэдэгдсэн тохиолдолд уг үйл ажиллагаанд татвар төлөгчийг, урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд хөндлөнгийн гэрч, эсвэл татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг оролцуулж болно.
- 14.1.3. Ажлын зураг авалтад төрөл бүрийн хэмжих хэрэгсэл ашиглаж холбогдох мэргэжилтэн оролцуулж болно.
- 14.1.4. Татварын улсын байцаагч ажлын зураг авалтын тэмдэглэл, тооцоог хөтөлж, оролцсон этгээдүүд гарын үсэг зурна. Ажлын зураг авалтад оролцсон аливаа этгээд тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тайлбарыг тэмдэглэлд бичнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөл зохих татварын ногдлыг тодорхойлох, бүртгэх, барагдуулах

15 дугаар зүйл. Татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах

- 15.1. Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана. Татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл Татварын алба, байцаагч шалган тогтооно.
- 15.2. Татвар төлөгч хуульд заасан хугацаанд татварын тайланг тушаагаагүй буюу тушаасан боловч түүнд татварын ногдлыг тусгаагүй бол Татварын алба, байцаагч өөрт байгаа мэдээ, баримтад тулгуурлан тодорхойлох, шалгах, жишгээр ногдуулах үндсэн дээр татварын ногдлыг тодорхойлно.
- 15.3. Татварын алба, байцаагчийн татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах бүрэн эрх нь татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал хүчин төгөлдөр байна.

16 дугаар зүйл. Татварын ногдлыг бүртгэх

- 16.1. Татварын алба татварын ногдол, төлөлтийн бүртгэлийг хууль тогтоомжинд нийцүүлэн Үндэсний Татварын Ерөнхий Газраас гаргасан журам, заавар, аргачлал, зөвлөмжийн дагуу татвар татвар төлөгч бүрээр хөтөлнө.

17 дугаар зүйл. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга

- 17.1. Ашгийн төлөө аливаа үйлдвэрлэл, ажил үйлчилгээ явуулж байгаа болон явуулж байсан нь нотлогдсон боловч үйл ажиллагааныхаа баримтыг бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн, эсхүл баримт бүртгэл, татварын тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг Татварын албаны даргын шийдвэрийн дагуу бусад татвар төлөгчтэй харьцуулан жишгээр татвар ногдуулах шийдвэр гаргана.
 - 17.1.1. Бодит үнийн арга
 - 17.1.2. Жишгээр тодорхойлох арга
- 17.2. Бодит үнийн арга гэж харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ нь ийм харилцан хамааралгүй этгээдийн хооронд хийгдсэн үнээс ялгаатай байвал зах зээлийн ердийн нөхцөлд хэрэглэж болох байсан үнийг харьцуулалт тооцоололтын аргыг ашиглан тогтоохыг хэлнэ.

- 17.3 Татварын ногдлыг тусгайлсан аргаар тодорхойлох аргачлыг ҮТЕГ тогтооно.
- 17.4 Татвар төлөгч нь Монгол улс болон гадаад улсад байгаа харилцан хамаарал бүхий этгээдүүдтэй хийсэн үйл ажиллагаандаа (борлуулалт, худалдан авалт, боловсон хүчин илгээх, техникийн үйлчилгээ үзүүлэх, хоршсон үйлдвэрлэл явуулах г.м) хэрэглэсэн үнэ, төлбөр, хураамж нь (цаашид «үнэ» гэх) бодит үнээс их буюу бага байвал татварын ногдлыг тодорхойлохдоо бодит үнийн аргыг хэрэглэнэ.
- 17.5 Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэрлэл үйлчилгээг тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол түүний, байхгүй бол ойролцоо орон нутагт орших татвар төлөгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татвар төлөгчийн татварын ногдлыг тодорхойлохдоо жишгээр тодорхойлох аргыг хэрэглэнэ.
- 17.6 Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйлдвэрлэл үйлчилгээг тухай орон нутагт эрхэлж буй татвар төлөгчийн үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлж, жишгээр татвар ногдуулах тохиолдолд тухайн татвар төлөгч нь өөрт байгаа баримт, тэмдэглэл, гар ноорог зэргийг гаргаж өгөх үүрэгтэй.
- 17.7 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох ажлыг тухайн татвар төлөгчийг хариуцан ногдуулалт хийж буй татварын байцаагч, хяналт шалгалт хариуцсан татварын байцаагчтай хамтран акт тогтоож, нөхөн төлөх татварын хэмжээг тогтооно. Тусгайлсан аргаар ногдуулсан татварын актыг тухайн татварын албаны дарга хянаж батална.
- 17.8 Татварын тайлан гаргаагүй болон үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэхдээ бүртгэл хөтлөөгүй, эсхүл баримт хөтөлж бүрдүүлээгүй татвар төлөгч нь татварын албаны тогтоосон жишиг татварыг үгүйсгэх эрхгүй.

18 дугаар зүйл. Мэдэгдэх хуудас гардуулах

- 18.1. Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татвар болон энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмаар Татварын албанаас тодорхойлон тогтоосон татварыг төлүүлэхээр дараахь агуулга бүхий мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулна.
 - 18.1.1. Татвар төлөгчийн овог, нэр
 - 18.1.2. Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар
 - 18.1.3. Мэдэгдэх хуудас бичсэн он, сар, өдөр
 - 18.1.4. Татвар ногдох зүйл
 - 18.1.5. Төлбөл зохих татварын хэмжээ
 - 18.1.6. Мэдэгдэх хуудас гардуулснаас хойш ажлын 10 хоногт багтаан татварыг төлөх шаардлага
 - 18.1.7. Татвар төлөх газар, хэлбэр
 - 18.1.8. Татварын ногдлыг тооцсон үндэслэл
 - 18.1.9. Татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад шаардлага

- 18.2. Татварын ногдлыг төлөхгүйд хүрч болзошгүй тохиолдолд Татварын албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаас богино хугацаанд татварыг төлүүлэхээр шийдэж болно.

19 дүгээр зүйл. Татварын өрийг барагдуулах дараалал

- 19.1. Хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд төлөөгүй татвар, хүү, торгуулийн өрийг дараахь дарааллаар барагдуулна.
- 19.1.1. Тухайн татварт ногдох хүү
- 19.1.2. Торгууль
- 19.1.3. Татварын үндсэн өр
- 19.2. Татварын төлбөрийг үүссэн цаг хугацааны дараалаар барагдуулна. Шинээр үүссэн татварын өрийг жил сараар нь ангилж үлдэгдэл өрийн хэмжээ болон төлсөн татварын хэмжээг бүртгэнэ.
- 19.3. Дараахь тохиолдолд татварын төлбөрийн дарааллыг Татварын алба тусгайлан тогтооно.
- 19.3.1. Хэрэв татвар төлөгч тухайн төлбөрийг аль хугацааны ямар татварт хамаарахыг заагаагүй
- 19.3.2. Эд хөрөнгө хураах замаар татварыг төлүүлж байгаа.
- 19.4. Татварын албанд бүртгэлтэй татварын төлбөрийг дараах журмаар барагдуулна.
- 19.4.1. Зах зээлд борлогдож болох эд хөрөнгийг хурааж, энэ хуулийн 26-р зүйлд заасны дагуу зохих үйл ажиллагаа хийсний дараа борлуулалт хийж, үнийг өр төлбөрт нь суутгана.
- 19.4.2. Татвар төлөгч эд хөрөнгөө нуух, худалдах, бусдад шилжүүлэх зэргээр үгүй хийж болзошгүй тохиолдолд уг хуулийн 38-р зүйлд заасны дагуу хөрөнгийг битүүмжилнэ. Мөнгөөр төлөөгүй тохиолдолд битүүмжилсэн эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.
- 19.4.3. Татвар төлөгчийн төлбөрийг энэ хуулийн 38-р зүйлд зааснаар зарим төрлийн тодорхой эд хөрөнгийг барьцаалан төлүүлнэ.
- 19.4.4. Татвар төлөгчийн өмчлөлд байгаа хувьцаа, үнэт цаасыг бусдад худалдах журмаар төлүүлнэ.
- 19.4.5. Татвар төлөгчийн өрийг тодорхой нөхцөл болзолтойгоор нийтэд зарлан худалдаж үнийг төсвийн орлогод оруулна.

20 дугаар зүйл. Татварын төллөхийг төлөх хугацааг сунгах

- 20.1. Татварын алба татвар төлөх хугацааг дараахь байдлаар тогтооно.
- 20.1.1. Татвар төлөгчид татварын ногдуулалтаар гарсан өр төлбөр буюу дутуу төлөлтийг ногдол хийсэн акт гардуулсан өдрөөс хойш ажлын 15 хүртэл хоногийн хугацаанд
- 20.1.2. Хяналт шалгалтаар илэрсэн нөхөн татвар, хүү, торгуулийн төлбөрийг актыг танилцуулсан өдрөөс хойш ажлын 10 хүртэл хоногийн хугацаанд

- 20.1.3. Бодит шалтгааны улмаас энэ зүйлийн 1, 2-г заасан болон энэ хуулийн 18-р зүйлийн 1-ийн 6-д заасан хугацаанд төлж чадаагүй бол татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тухайн Татварын албаны даргын тушаалаар 60 хүртэл хоногоор сунгаж болно.
- 20.2. Энэ зүйлийн 3 дэх хэсэгт заасны дагуу татвар төлөх хугацааг сунгахаар бол хожимдуулсан татварыг төлөх хуваарь, хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг татвар төлөгчөөс гаргуулан авна.
- 20.3. Татвар төлөх хугацааг сунгасан тохиолдолд хугацаа сунгасныг үл харгалзан хуульд заасан хугацаа хэтэрсний алданги ногдуулна.

21 дүгээр зүйл. Татварын төлбөр төлөх, суутган тооцох, буцаан олгох

- 21.1. Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 5-д заасан татвар төлөгчийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг дараахь журмаар шийдвэрлэнэ.
- 21.1.1. Төлбөл зохих бусад татварт суутган тооцох
- 21.1.2. Татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох
- 21.1.3. Буцаан олгох
- 21.2. Илүү төлсөн татварыг суутган тооцох бол энэ тухай Татварын алба татвар төлөгчид мэдэгдэнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Татвар хураах**

22 дугаар зүйл. Төлөөгүй татварыг хураах

- 22.1. Татвар төлөгч татвар, хүү, торгууль /цаашид «татварын төлбөр» гэх/-ийг хууль тогтоомжид заасан хугацаанд төлөөгүй бол Татварын алба түүнийг төлүүлэх талаар дараахь ажиллагаа явуулна:
- 22.1.1. Үл маргах журмаар төлүүлэх
- 22.1.2. Эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах
- 22.1.3. Эд хөрөнгө болон бусад орлогыг хурааж, худалдан борлуулах замаар төлүүлэх
- 22.1.4. Шүүхэд нэхэмжлэл гаргах
- 22.2. Татвар төлөгчийн төлөх ёстой татварын төлбөрийг бүрэн гаргуулах зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг давхар явуулж болно.

23 дугаар зүйл. Татварын төлбөрийг үл маргах журмаар төлүүлэх

- 23.1. Татварын төлбөрийг энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт болон 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд татвар төлөгчийн харилцагч банкин дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөнөөс татварын төлбөрийг үл маргах журмаар гаргуулна. Хэрэв татвар төлөгчийн харилцагч банкинд байгаа дансан дахь мөнгөн хөрөнгө нь татварын төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй байвал үг данснаас төлөх зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож дансны орлогоос төлбөрийг гаргуулан авна.
- 23.2. Татварын төлбөрийг үл маргах журмаар гаргуулах тухай татварын байцаагчийн мэдэгдэх хуудсыг тухайн Татварын албаны дарга баталж, банкны байгууллагад өгнө. Мэдэгдэх хуудсанд татварын төлбөр гаргуулах үндэслэл, түүний хэмжээ, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох хугацааны тухай заасан байна.

24 дүгээр зүйл. Татварын төлбөрийг татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос хураан авч бэлэн мөнгөөр тооцож хураах

- 24.1. Татвар төлөгч тус хуулийн 18.1.6, 18.2, 20.1, 2-т заасан хугацаанд татвараа төлөөгүй, мөн тус хуулийн 23-р зүйлд заасны дагуу татварын төлбөрийг үл маргах журмаар гаргуулан авах боломжгүй тохиолдолд татварын алба татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин болон бусад орлогоос бэлэн мөнгөөр тооцож гаргуулан авна.
- 24.2. Татварын төлбөрт авсан эд хөрөнгө болон бусад зүйлийн үнэлгээг хийхдээ хуульд заасан журмын дагуу явуулж, татварын төлбөрийг барагдуулна.

25 дугаар зүйл. Татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулах

- 25.1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөр гаргуулахдаа дараахь журмыг баримтална.
- 25.1.1. Цалин хөлс, бусад орлогоос татварын төлбөрт суутгал хийлгүүлэхээр татвар төлөгчид орлого олгож байгаа буюу түүний ажиллаж байгаа үндсэн аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийн хуудас хүргүүлнэ.
- 25.1.2. Аж ахуйн нэгж, байгууллага төлбөрийн хуудсыг хүлээн авмагц татвар төлөгчийн орлогоос зохих суутгалыг сар тутам хийж, суутгал хийснээс хойш 3 хоногийн дотор уг мөнгийг төлбөрийн хуудсанд заасан дансанд шилжүүлнэ.

- 25.1.3. Татварын төлбөрийг шүүхийн шийдвэрийн дагуу цалин, орлогоос нь суутгал хийж байгаагаас бусад төлбөрийн өмнө суутгана.
- 25.1.4. Татвар төлөгч ажлаас халагдвал аж ахуйн нэгж, байгууллага нь түүний халагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор татварын төлбөрт суутгасан мөнгөний хэмжээ, хаана шилжсэнийг тэмдэглэж төлбөрийн хуудсыг Татварын албанд буцаана.

26 дугаар зүйл. Татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын төлбөр гаргуулах

- 26.1. Татварын төлбөрт өгөх эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал, татвар төлөгчийн санал, орон нутгийн тухайн үеийн ханшийг харгалзан хураасан эд хөрөнгийг худалдах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, худалдаа эхэлсэн өдрөөс 30 хоногийн дотор уг эд хөрөнгө борлогдохгүй тохиолдолд борлогдох үнээр нь борлуулж, орлогыг төсөвт оруулна.
- 26.2. Татварын төлбөрт өгөх эд хөрөнгийг нийтэд зарлан худалдахад татвар төлөгч хүсвэл өөрөө, эсхүл өөрийн төлөөний этгээдийг байлцуулж болно.
- 26.3. Борлогдсон эд хөрөнгийн үнийн дүн татварын төлбөр, борлуулалтын зардлаас давсан тохиолдолд тус хуулийн 21-р зүйлийн дагуу шийдвэрлэж, түүний бүртгэлийг хөтлөх.
- 26.4. Нийтэд зарлан мэдээлсний үндсэн дээр худалдаалсан эд хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө. Татварын нэрийн дэлгүүрээр худалдан борлуулсан эд хөрөнгөөс орох орлогыг 3 хоногийн дотор тухайн татвар төлөгчийн нэр дээр төсөвт оруулна.
- 26.5. Татварын төлбөрт авах эд хөрөнгийн борлуулах үнэ бүүрсан тохиолдолд тухайн татвар төлөгч үүнийг буцаан авч, татварын төлбөрийг бэлэн мөнгөөр хийж барагдуулна.

27 дугаар зүйл. Татварын төлбөрийг гаргуулах тухай шүүхэд нэхэмжлэл гаргах

- 27.1. Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 2 дахь хэсэг болон 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд татварын төлбөрийг татвар төлөгч төлөөгүй, уг төлбөрийг энэ хуулийн 24, 25 дугаар зүйлд заасан журмын дагуу барагдуулах боломжгүй тохиолдолд Татварын алба татварын төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана. Шүүх нэхэмжлэлийг хүлээн аваад хуулийн заалтын дагуу шийдвэр гаргахдаа татварын албанаас төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон алданги, хүү, торгуулийг үндэслэлгүйгээр багасгах, хүчингүй болгож болохгүй.

- 27.2. Хэрэв татвар төлөгч татвараа төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татварын төлбөрт эд хөрөнгө гаргах ажиллагааг саатуулсан, татгалзсан бол Татварын алба татварын хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, хэргийг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Тавдугаар бүлэг
Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт

28 дугаар зүйл. Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт бичих дүгнэлт

- 28.1. Татварын улсын байцаагч нь энэ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр акт, 7-ийн 7-д заасан үндэслэлээр дүгнэлт бичнэ.
- 28.2. Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт нь түүнийг татвар төлөгчид танилцуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Татварын улсын байцаагч татвар төлөгчид акт, дүгнэлтийг танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Акт, дүгнэлтийг татварын албаны хяналт шалгалт хариуцсан хэлтэс, тасгийн дарга хянан үзэж гарын үсэг зурж баталгаажуулна. Акт, дүгнэлт нь нэгдсэн бүртгэл, дугаартай байна.
- 28.3. Татварын улсын байцаагч акт, дүгнэлтийг 3 хувь үйлдэж, нэг хувийг татвар төлөгчид өгч, хоёрдахь хувийг хяналт шалгалтын бичиг баримтад, гуравдахь хувийг татвар төлөгчийн хувийн хэрэгт хадгална.

29 дүгээр зүйл. Татварын улсын байцаагчийн актыг биелэлтийг хангах

- 29.1. Татварын алба, татварын улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнд биелэгдэхгүй байгаа акт, дүгнэлтийн талаар татварын алба, татварын улсын байцаагч хууль тогтоомжийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргана.
- 29.2. Татварын алба, татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийн биелэлтэд уг байцаагчийн харъяалах хэлтэс, тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч болон тухайн татварын албаны дарга хяналт тавина.

30 дугаар зүйл. Татварын улсын байцаагчийн актыг өөрчлөх, хүчингүй болгох

- 30.1. Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн татварын албаны даргын тушаалаар уг акт, дүгнэлтийг өөрчлөх буюу хүчингүй болгоно.
- 30.2. Татварын алба, татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийн үндэслэлийг татварын албаны даргын тушаалаар томилогдсон комисс тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ **Бусад этгээдийн үүрэг**

31 дүгээр зүйл. Татварын үйл ажиллагааны талаар банк, санхүүгийн байгууллагын хүлээх үүрэг

- 31.1. Банк, санхүүгийн бусад байгууллага татварын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар дараахь үүрэг хүлээнэ:
- 31.1.1. Татвар төлөгчийн тооцооны болон бусад данс /цаашид «данс» гэх/-ыг Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу шинээр нээсэн болон дансны дугаарын өөрчлөлт хөдөлгөөний тухай мэдээллийг ажлын 10 хоногийн дотор Татварын албанд мэдэгдэх;
- 31.1.2. Дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө татварын төлбөр хийх тухай татвар төлөгчийн болон, үл маргалдах журмаар татвар, хүү, торгууль төлүүлэх тухай Татварын албаны шийдвэрийг хуульд заасны дагуу эхний ээлжинд банк, санхүүгийн байгууллага, түүнчлэн бусад зээлдэгч, нэхэмжлэгчид төлөх төлбөрөөс өмнө биелүүлэх. Энд заасны дагуу татварын төлбөрийг гүйцэтгэхэд Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй;
- 31.1.3. Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу тогтоосон хугацаанд татвар төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох тухай Татварын албаны шийдвэрийг хэрэгжүүлэх.

32 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үүрэг

- 32.1. Татварын алба, байцаагчаас татвар төлөгчийн байр, агуулахад нэвтрэн орох болон шалгалт, тооллого, үзлэг явуулах үйл ажиллагааг хүч хэрэглэх буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн тохиолдолд цагдаагийн байгууллага шаардлагатай туслалцаа үзүүлж, уг үйл ажиллагааг явуулах бололцоог хангана.
- 32.2. Цагдаагийн байгууллага нь Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон хувь хүний нууцад үл хамаарах өөрт байгаа мэдээ, судалгааг Татварын албаны хүсэлтээр гаргаж өгнө.

32.3. Цагдаагийн байгууллага нь татвар төлөхөөс зайлсхийн оргон зайлж олдохгүй болсон аж ахуйн нэгж, татвар төлөгчдийг эрэн сурвалжлах ажилд туслалцаа үзүүлж хамтран ажиллахаар татварын албаны хүсэлтийн дагуу улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулна.

33 дугаар зүйл. Бусад этгээдийн үүрэг

33.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагааныхаа явцад илрүүлсэн татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Татварын албанд шилжүүлж өгөх үүрэгтэй.

33.2. Гаалийн байгууллага нь гаалийн мэдүүлэгт татвар төлөгчийн бүртгэлийн дугаарыг тусгаж байгаа эсэхийг хянаж, татвар төлөгчийн экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг Татварын албаны хүсэлтээр гарган өгч байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

34 дүгээр зүйл. Хүү, торгууль ногдуулах, төлүүлэх журам

34.1. Татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд татвар төлөхөөр хуульд заасан өдрөөс татвар төлсөн өдрийг хүртэлх хугацаанд хүү ногдуулна.

34.2. Татварын албаны буруугаар илүү төлөгдсөн татварыг буцаан олгох бол татварыг төсөвт төлсөн өдрөөс эргүүлэн олгосон өдрийг хүртэлх хугацаанд буцаасан татварын дүнгээс бодож өдөр тутам 0,3 хувийн хүү төлнө. Энэ хүүг төсвөөс гаргана.

35 дугаар зүйл. Гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэх

35.1. Татварын үйл ажиллагаатай холбоотой татвар төлөгчийн гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэхэд энэ хууль болон татварын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөнө.

35.2. Татварын үйл ажиллагаатай холбоотой татварын улсын байцаагчийн шийдвэрийн талаархи татвар төлөгчийн гомдлыг дараахь журмаар хүлээн авч шийдвэрлэнэ:

- 35.2.1. Татварын улсын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн байцаагчийн ажилладаг Татварын албанд;
- 35.2.2. Татварын алба, албаны даргын шийдвэрийн талаархи гомдлыг түүний дээд шатны Татварын албанд;
- 35.2.3. Уг зүйлийн 2-ын 1, 2-т заасан гомдлыг хүлээж аваагүй тохиолдолд Татварын дээд шатны албанд;

36 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

- 36.1. Татвар төлөгч уг хуулийн 35-р зүйлийн 2, 3-т заасан дарааллын дагуу гомдлоо гаргасан боловч түүнийг барагдуулаагүй тохиолдолд л шүүхэд гомдол гаргах эрхтэй. Мөн татвар төлөгчтэй холбоотой шалтгааны улмаас хуулиар тогтоосон татварын тайлан гаргах хугацаа, хуулиар тогтоосон татвар төлөх хугацаа зэрэг татвартай холбоотой хуулийн заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд шүүхэд гомдол гаргах эрхгүй.

37 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх үндэслэл

- 37.1. Татварын алба, татварын байцаагч татварын өртэй татвар төлөгчийн эд хөрөнгө, мөнгө, бичиг баримт, бүртгэлийн дэвтэр, оршин суугаа газар, агуулахыг (хойшид «хөрөнгө» гэх) дор дурдсан шалтгаан болон цаг хугацаагаар барьцаанд авч, эсвэл битүүмжилж, хураан авч болно
 - 37.1.1. Татвар төлөгч татварын байгууллагын тогтоосон хугацаанд татвар, алданги, нөхөн татвар, торгууль зэргийг төлөлгүй удаашруулсан тохиолдолд;
 - 37.1.2. Татварын хяналт шалгалт, тооллого, ажлын зураг авалт хийхдээ эдгээр шалгалтыг хийж, дүгнэлт гаргах хүртэлх хугацаа, эсвэл шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаа;
 - 37.1.3. Татвар төлөгч татварын хуулинд заасан болон татварын байгууллагын тогтоосон хугацаанд татвар төлөөгүй тохиолдолд болон төлөхгүй магадлал байх тохиолдолд
- 37.2. Татварын алба нь үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж барьцаанд авах, эсвэл хурааж авахдаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт мэдэгдэнэ.
- 37.3. Битүүмжилсэн эсвэл барьцаанд авсан эд хөрөнгийг тухайн эзэмшигчийн байнгын хамгаалалд байлгана.
- 37.4. Татварын алба битүүмжилж барьцаалахаар авсан эд хөрөнгийн талаар 60 хоногийн дотор дараах арга хэмжээг авна.
 - 37.4.1. Татварын алба татвар төлөгч татварын өрөө бэлэн мөнгөөр төлөх боломжгүй үед битүүмжилж, эсвэл барьцаалсан эд хөрөнгийг хурааж аван хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд

зарлан худалдана. Мөн хураан авсан эд хөрөнгө ч үүнд хамаарна.

- 37.4.2. Тус хуулийн 37-р зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь дэд хэсэгт заасан хугацаа дууссан тохиолдолд битүүмжилж, эсвэл барьцаалж авсан эд хөрөнгийг татвар төлөгчид буцаан олгоно.
- 37.4.3. 37-р зүйлийн 1 дэх хэсгийн 3 -т заасан хугацаа дуусах үеэс, мөн татвар төлөхийг шаардсан нэхэмжлэл гарсны дараа сайн дураар татвараа төлөөгүй нь тогтоогдсон үеэс битүүмжилж барьцаалж авсан эд хөрөнгийг худалдах эрх үүснэ.

38 дугаар зүйл. Эд хөрөнгө барьцаалах журам

- 38.1. Татвар төлөгч нь ногдуулсан буюу актаар тавигдсан татвар, алданги, торгуулийг хуульд заасан хугацаанд төлөх бололцоогүй нь тодорхой болсон тохиолдолд, эсвэл мөнгөн хэлбэрээр төлөх боломжгүй нь банкин дахь данс болон түүний кассын үлдэгдлээр батлагдсан тохиолдолд тодорхой эд хөрөнгийг барьцаална.
- 38.1.1. Татварын төлбөрийн барьцаанд авсан эд хөрөнгө нь тухайн татвар төлөгчийн өөрийн өмч байна.
- 38.1.2. Эд хөрөнгийг барьцаанд авахдаа барьцаалагч, барьцаалуулагч хоёр гэрээ хийж, уг эд хөрөнгийн чанар, үнэ, хэлбэр хэмжээ, байршил, хэний эзэмшилд хаана байхыг тодорхой заана. Хэрвээ үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бол үл хөдлөх хөрөнгийн газарт бүртгүүлнэ.
- 38.1.3. Барьцааны гэрээний хугацааг гэрээнд оролцогч талууд тохиролцож тогтооно. Гэрээний хугацаа дуусмагц барьцаалсан хөрөнгө татварын албаны мэдэлд шилжинэ. Барьцааны эд хөрөнгийг худалдахдаа энэ хуулийн 26-р зүйлийн 3-т заасан журмыг баримтална.
- 38.1.4. Эд хөрөнгөө барьцаалуулагч гэрээнд заасан хугацааны дотор татварын төлбөрийг барагдуулж барьцаанд тавьсан эд хөрөнгөө буцааж авах эрхтэй. Барьцаалуулагч уг эд хөрөнгийг ашиглах, захиран зарцуулах, гэмтээх, устгах эрхгүй. Хэрвээ барьцаалсан эд хөрөнгөнд хохирол учруулбал хариуцлагыг хүлээнэ.
- 38.1.5. Барьцааны эд хөрөнгийг худалдсан дүн нь татвар төлөгчийн татварын өр төлбөрийн хэмжээнд хүрэхгүй бол татвар төлөгч үлдсэн төлбөрөөс чөлөөлөгдөхгүй.
- 38.1.6. Татвар төлөгчийн дараах эд хөрөнгийг битүүмжилж, барьцаалж, хурааж болохгүй.

1. Татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн өдөр тутам хэрэглэдэг хувцас хэрэглэл
2. Татварын өртэй татвар төлөгчийн эзэшилд хамаарахгүй эд хөрөнгө
3. Удаан хадгалах боломжгүй түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн
4. Хуучирч элэгдэн хэрэгцээ хангахгүй болсон эд зүйлүүд
5. Татвар төлөгчийн байнга амьдран суугаа байр орон сууц
6. Хүйтний улиралд түлээ нүүрс

39 дүгээр зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх журам

- 39.1. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг тооллого, үзлэг, шалгалт хийхээр томилогдсон татварын улсын байцаагчид гүйцэтгэнэ.
- 39.2. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа явуулахад татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, итгэмжлэгдсэн нягтлан бодогч, хэрэв боломжгүй бол тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.
- 39.3. Эд хөрөнгийг битүүмжилсан тухай татварын улсын байцаагч акт, тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд эд хөрөнгийн хэлбэр, хэмжээ, чанар, тоо, өнгө, шинж тэмдгийг тусгана. Актэд эд хөрөнгийг битүүмжилсэн үндэслэл, хугацааг заана.
- 39.4. Эд хөрөнгийг битүүмжлэхэд хөндлөнгийн гэрч, эсвэл татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг байлцуулна. Хөндлөнгийн гэрч, эсвэл татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны бүх үйл явцыг нотлох үүрэг хүлээх бөгөөд уг ажиллагаанд түүнийг оролцуулсан тухай тэмдэглэлд гарын үсэг зурна.
- 39.5. Битүүмжилсэн эд хөрөнгийг лацдах буюу ломбодож эзэмшигчид нь хариуцуулан өгнө. Үүргээ зөрчвөл энэ хуулийн 41-р зүйлийн 1-ийн 6-д заасан хариуцлага хүлээнэ.
- 39.6. Эзэмшигч нь түүнд хариуцуулан өгсөн эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах, татварын албаны зөвшөөрөлгүйгээр лац, домбо, түгжээг хөдөлгөх, битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, бусдад худалдах, шилжүүлэхгүй байх үүрэгтэй. Эзэмшигч үүргээ биелүүлээгүй тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагын талаар татварын улсын

байцаагч түүнд тайлбарлаж, энэ тухай тэмдэглэлд тусган эзэмшигчээр гарын үсэг зуруулна.

40 дүгээр зүйл. Үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа эрхлэх үйл ажиллагааг түр зогсоох

- 40.1. Татварын ногдлыг тодорхойлох хяналт шалгалтын явцад хууль тогтоомж ноцтой зөрчсөн нь тогтоогдвол татвар төлөгчийн үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа эрхлэх үйл ажиллагааг татварын алба уг зөрчил болон түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилган шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн татварын албаны даргын тушаалаар түр зогсоож болно.
- 40.2. Татвар төлөгч буюу түүний хууль ёсны төлөөлөгч энэ хуулийн 37, 38 дугаар зүйл, энэ хуулийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаатай холбогдсон гомдлоо тухайн татварын албанд гаргаж болно. Татвар төлөгчийн гомдлыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны татварын албанд гомдол мэдүүлж болно. Дээд шатны татварын алба хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд татварын төв байгууллагад гомдол гаргаж болно. Татварын төв байгууллага тухайн гомдлыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд л шүүхэд нэхэмжлэл гаргана.

41 дүгээр зүйл. Хүлээлгэх хариуцлага

- 41.1. Татварын хуулийг зөрчсөн татвар төлөгч, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:
- 41.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, нягтлан бодогч болон татвар төлөгч иргэд энэ хуулийн энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7 дахь хэсэгт заасан болон улсын бүртгэлийн журмыг зөрчиж тогтоосон хугацаанд татварын албанд бүртгүүлээгүй тохиолдолд, эсвэл татвар төлөгч Монгол улсад оршин суух хугацааг буруу тодорхойлох замаар татварын тайлан гаргаж татвар төлөөгүй, мөн орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч иргэн сар бүрийн албан татвар төлөлгүй ажил үйлчилгээ үзүүлсэн эсвэл тоо хэмжээгий нь засварласан буюу хуурамч баримт ашигласан бол 30000-1 сая төгрөгөөр торгох;
- 41.1.2. Татвар төлөгч хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого болон бусад татвар ногдох зүйлийг тодорхойлохтой холбогдсон баримт материалыг бүрдүүлээгүй, анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, татвар ногдох орлогыг дутуу бичилт хийж нуусан, зардлаа үндэслэлгүйгээр өсгөсөн, татварын хөнгөлөлт

- чөлөөлөлтөд орох нөхцлийг буруу тодорхойлсон, татварын тооцоо хийхэд шаардлагатай гадаад хэл дээрх баримтыг монгол хэл дээр орчуулаагүй, санхүү татварын холбогдолтой баримт бүртгэлийг хөөн хэлэлцэх хугацаанд хадгалаагүй бол буруутай этгээдийг 3000-1 сая төгрөгөөр торгох;
- 41.1.3. Татвар төлөгч нь татварын ерөнхий хуульд заасан татвар төлөгчийн үүргийг биелүүлээгүй, татвараа татварын тайлан орлого тодорхойлох хуудсаар хуулиар тогтоосон хугацаанд харъяалагдах татварын албанд тушаагаагүй, татварын тайланд гарын үсэг зураагүй, татварын тооцоог татварын итгэмжлэгдсэн бодогчоор баталгаажуулаагүй, тамга тэмдэг дараагүй бол 30000-1 сая төгрөгөөр торгох;
- 41.1.4. Татварын хуулинд заасан дундын суутгал хийгээгүй, татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн, тэр тухайгаа татварын албанд мэдэгдээгүй гэм буруутай этгээдийг 50000-1 сая төгрөгөөр торгоно.
- 41.1.5. Татварын алба, татварын улсын байцаагч, татварын хэрэг бүртгэгчээс өгсөн мэдэгдэл, акт, мэдэгдэх болон төлбөрийн хуудас, шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, тэдэнд шаардлагатай мэдээ баримтыг гаргаж өгөөгүй, байр агуулахад нэвтрэн орох, үзлэг шалгалт хийх, эд хөрөнгө тоолох, ажлын зураг авалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах үйл ажиллагааг эсэргүүцэх, саад учруулах, дарамт шахалт үзүүлэх зэргээр тэдний хэвийн ажиллагаанд хүндрэл учруулбал 50000-2 сая төгрөгөөр торгоно. Татварын байцаагч үүргээ гүйцэтгэхэд нь ноцтой саад учруулсан тохиолдолд захиргааны хариуцлагын хуулийн дагуу баривчилна.
- 41.1.6. Татварын байцаагчийн битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг худалдсан, үрэгдүүлсэн, бусдад шилжүүлсэн, гэмтээсэн бол буруутай этгээдийг 50000-5 сая төгрөгөөр торгож, уг хөрөнгийн үнийг төлүүлнэ.
- 41.1.7. Татварын албанаас хууль зөрчсөн учир татвар төлөгчийн үйлдвэрлэл, худалдаа, ажил үйлчилгээ эрхлэхийг зогсоосон шийдвэрийг үл биелүүлсэн этгээдийг 50000-5 сая төгрөгөөр торгож, хууль бус орлогыг хурааж үйлдвэрлэл, худалдаа, ажил үйлчилгээ явуулахад ашигласан тоног төхөөрөмж, машин техник, орон байр, агуулах савыг хурааж, улсын орлого болгоно.
- 41.1.8. Татварын албатай байнга харилцдаг байгууллагын албан тушаалтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд 50000-5 сая төгрөгөөр торгоно.
- 41.1.9. Банкны ажилтан энэ хуулийн 31-р зүйлд заасны дагуу татварын албанаас банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох мэдэгдэл, мэдэгдэх хуудсыг хүлээн авч биелүүлээгүй,

татвар, алданги, торгуулийн орлогыг эхэнд шилжүүлээгүй, татварын байцаагчаас шаардсан аж ахуйн нэгж байгууллагын дансан дахь орлогын гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргаж өгөөгүй, дансны дугаарын өөрчлөлтийг мэдээлээгүй бол

41.1.10. Цагдаагийн байгууллагын ажилтан энэ хуулийн 32-р зүйлд заасан татвар төлөгчийн бүртгэл, хаяг байршлын тодорхойлолтыг үнэн зөв гаргаж өгөөгүй, оргон зайлагчийг эрэн сурвалжлахтай холбогдсон үүргээ биелүүлээгүй, татварын албаны хүсэлтээр зохих туслалцаа үзүүлээгүй бол

41.1.11. Гаалийн байгууллагын ажилтан татвар төлөгчийн импорт, экспортын үйл ажиллагааны тухай судалгаа, мэдээ мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөөгүй бол

41.1.12. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан шүүхий шийдвэр биелүүлэх тухай хуулинд зааснаар төсөвт орох төлбөрийг эхний ээлжинд барагдуулаагүй, хурааж авсан төлбөрийг шилжүүлэлгүй 3 хоногоос дээш хугацаагаар саатуулсан бол

41.1.13. Санхүүгийн байгууллагын ажилтан энэ хуулийн 31-р зүйлд заасан үүрэг болон мэдээ, тайлан бүртгэл, зардалтай холбогдсон мэдээ мэдээллийг гаргаж өгөөгүй бол

42 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 200... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.